

**ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.ТАМИРААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2024.01.02-06.25.

**1.1.ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ
БОЛОН ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ УЛСЫН ИХ ХУРЛААР
БАТЛУУЛАХААР САНГИЙН ЯАМАНД ХҮРГҮҮЛЭХ**

СУУРЬ ТҮВШИН

1.Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн.

Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг “Санал шийдвэрлүүлэх тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн.

ХЭРЭГЖИЛТ

“Ажлын хэсэг байгуулах тухай” ГЕГ-ын даргын 2023 оны №А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрүүдэд ажилласан.

Энэ хугацаанд 2021-2023 онд шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн.

Мөн гаалийн байгууллагын чиг үүрэгт шинээр орсон хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын асуудлыг шинээр бүлэг болгон Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.

Түүнчлэн гадаад улсуудын жишиг, УИХ-ын гишүүдтэй хийсэн уулзалт дээр өгсөн чиглэлийн дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлд нэгтгэн найруулав.

Гаалийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн найруулсан.

ДГБ-ын багц стандарт, гарын авлага, бусад орны хууль тогтоомжуудыг судалж, Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенци /Киото контенци/ болон түүнд оруулах өөрчлөлтүүд, ДГБ-аас өгсөн зөвлөмжүүдтэй танилцсан.

Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүд, гаалийн газар хороодоос ирсэн саналуудтай нэгбүрчлэн танилцаж, ирсэн саналуудыг бүлэглэн хуулийн төслийн холбогдох хэсгүүдэд тусган, хүлээн авах боломжгүй саналуудын шалтгааныг тэмдэглэн ажиллав.

Хуулийн төслийн холбогдох заалтуудыг боловсруулах үед ГЕГ-ын холбогдох бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, гарч буй хүндрэл, хуулиар зохицуулах шаардлагатай байгаа асуудлууд, худалдаа хөнгөвчлөх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын талаар ярилцаж саналуудыг тусган ажилласан болно.

I хэсэг.Ерөнхий зүйл

Хуулийн зорилго, томъёоны тодорхойлолт хэсэгт буюу I-IV бүлэгт хорио цээрийн хяналт шалгалттай холбоотой асуудлыг нэмж тусгасан.

II хэсэг.Мэдээлэл, зөвлөгөө лавлагаа, гомдол

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Захиргааны ерөнхий хууль, ДХБ-ын ХХХ-т заасан “Хэвлэл нийтлэл болон мэдээллийн хүртээмж”, “Цахим төлбөр”, “Гомдол гаргах болон гомдлыг хянан шалгах ажиллагаа”, Гаалийн бүрдүүлэлтийн горимыг уялдуулах, хялбарчлах тухай конвенцийн “Мэдээлэл технологи ашиглах”, Статистикийн тухай хууль, Нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлийг хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг судалсан.

Мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа, гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах, гаалийн статистик, мэдээллийн технологи ашиглахтай холбогдсон харилцааг Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Мэдээллийн технологийн газраас ирүүлсэн санал, холбогдох хууль тогтоомжийн заалтуудтай уялдуулан боловсруулсан.

III хэсэг.Гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх, чөлөөлөх

Гаалийн тарифын тогтолцоо, гаалийн татвар тогтоох хэлбэр, гаалийн тарифын зөвлөл, гаалийн үнэ, барааны ангилал, импортын барааны гарал үүсэл, урьдчилсан шийдвэр, гаалийн болон бусад татвар ногдуулах, төлөх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг тусгана. урьдчилсан шийдвэр, барааны ангилал, гаалийн үнэлгээний асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд гаалийн болон бусад татварыг төлөх баталгаа, эсхүл татварыг холбогдох дансанд байршуулан барааг олгох болон татвар, тарифтай итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн гаалийн болон бусад татвар төлөх хугацааг уян хатан болгохтой холбогдсон бусад харилцааг нарийвчлан тусгасан.

IV хэсэг.Гаалийн хяналт, бүрдүүлэлт

Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн II-X бүлэг буюу 28-186 зүйлд гаалийн хяналт, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх, барааг мэдүүлэх, зарим нэр төрлийн барааг хилээр нэвтрүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх онцлог, гаалийн шалгалттай холбоотой үйл ажиллагааг тусгасан.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн хяналт, шалгалттай холбоотой асуудлыг хуулийн төсөлд нэг бүлэг болгон нэмж тусган, хорио цээрийн хяналтын ангилал, хамрагдах бараа, тавигдах нийтлэг шаардлага, хорио цээрийн үзлэг, халдваргүйжүүлэлт, барааг буцаах зэрэг зохицуулалтуудыг ажлын хэсгийн гишүүд болон Хорио цээрийн хэлтэстэй хамтран боловсруулсан.

Гаалийн мэдүүлэг, түүний төрөл, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх, урьдчилан мэдүүлэх, мэдүүлэх хугацаа, мэдүүлэгчийн эрх, үүрэг, барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримт, гаалийн мэдүүлэгт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хорио цээрийн хяналттай уялдуулан боловсруулсан.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрсдлийн мэдээлийн сан, эрсдэл тооцох үйл ажиллагааг тодорхой болгож, хорио цээрийн эрсдэлийн удирдлагыг гаалийн эрсдэлийн удирдлагатай уялдуулан найруулсан болно.

Гаалийн хяналтад орчин үеийн дэвшилтэт техник технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, гаалийн тэмдэглэгээ хийхэд ухаалаг ломбо ашиглах заалт, гаалийн магадлан шинжилгээнд ирүүлэх барааны тоо тэмжээг тогтоох заалт нэмж оруулсан.

Гаалийн итгэмжлэгдсэн операторын зохицуулалтыг шинээр оруулсан.

Зөвшөөрлийн тухай хуульд Гаалийн түр агуулах ажиллуулах үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан тул хуульд нийцүүлэн нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан.

Гаалийн хяналтын бүс тогтоох, сунгах, түдгэлзүүлэх, татан буулгах, Гаалийн тээвэрлэгчээр бүртгэх үйл ажиллагааг цахимд шилжүүлсэнтэй холбоотой тавигдах нөхцөл, шаардлага, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг бусад зөвшөөрөлтэй уялдуулсан.

Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалттай холбогдсон харилцааг тодорхой тусгаж, шалгалтын төрөлтэй холбоотой хэсгийг өөрчлөн найруулж, гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтаар гаалийн байгууллагад барааг мэдүүлээгүй, өөр бараагаар, эсхүл дутуу мэдүүлсэн зэрэг зөрчилд шийтгэл ногдуулсан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш барааг гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн бүрдүүлэлт хийлгэх, бусад зөрчилд шийтгэлийн хуудсаар шийдвэрлэхээр төсөлд тусгав.

V хэсэг.Гаалийн бүрдүүлэлтийн горим

Гаалийн тухай хуулийн шинчилсэн найруулгын төслийн 189-307 дугаар зүйлд Гаалийн бүрдүүлэлтийн горимын ангилал, төрөл, тэдгээрийг сонгох, барааг гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах, гаалийн болон бусад татвар төлөх үүрэг үүсэх, гаалийн болон бусад татвар ногдуулах, тарифын бус хязгаарлалт, горимд байршуулахаас татгалзах, эрх шилжүүлэх, бараа, тээврийн хэрэгслийг буцаан гаргах, буцаан оруулах, гаалийн зөрчлийн улмаас горимын үйлчлэл дуусгавар болох, гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын кодтой холбогдсон харилцааг дахин хянаж, зарим зүйл, хэсэгт найруулгын өөрчлөлт оруулсан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон г захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглосон тул гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг тодорхой тусгасан, гаалийн баталгаат агуулахад тавих нөхцөл, шаардлагыг тодорхойлсон.

Татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийг сонон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор зохицуулсан байсан боловч УИХ-аас 2023.01.06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт баталсан Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг судалж үзэхэд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгохоор зохицуулсан.

Гэвч 2023.01.06-ны өдөр батлагдсан Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 1 дэх

хэсэгт 139.1.17.заалт нэмж, татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалтад оролцох тохиолдолд бүрдүүлэх бичиг баримтыг тогтоосон байна.

Дээрх 2 хуульд зарчмын зөрүүтэй зохицуулалт орсон тул татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрөл олгох асуудлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор төсөлд найруулж, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн барихаар боловсруулсан болно.

VI хэсэг.Гаалийн албаны тогтолцоо

Гаалийн албаны тодорхойлолт, тогтолцоо, удирдлага, санхүүжилт, түүний үйл ажиллагааны зарчим, гаалийн байгууллага, түүний удирдлага, алба хаагчийн эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлсон.

Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай хамт өргөн барих хууль хүчингүй болгох, дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг боловсруулсан болно. Үүнд:

-Гаалийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль,

-Гаалийн тариф, гаалийн татварын хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль,

- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль,

-Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль,

-Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль,

-Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль,

-Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

-Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

ХҮРСЭН ТҮВШИН

Ажлын хэсэг Гаалийн тухай хуулийн төслийг 6 бүлэг 395 зүйлтэйгээр боловсруулсан бөгөөд хуулийн төслийн тандан судалгаа, зардлын тооцоо, үзэл баримтлалын төсөл, дагаж батлагдах хуулийн төслүүд зэрэг холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулсан.

Хуулийн төсөлд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийг нэгтгэсэн.

Хуулийн төсөл, холбогдох бусад материалын хамт Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд тус яамнаас 2024 онд Улсын Их Хурлын сонгуулийн жил бодлогын шинжтэй хуулийн төсөл хэлэлцэхгүй гэсэн чиглэл өгсөн ба одоогийн байдлаар тус яаманд хуулийн төслийг хэлэлцэж эхлээгүй байна.

Улсын Их Хурлын сонгуулийн дараа Сангийн яаманд дахин хандаж чиглэл авахаар төлөвлөж байна.

1.2.ГЕГ-ЫН ДАРГЫН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД БАТЛАН ГАРГАСАН НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДӨХ ЭРХ ЗҮЙН АКТАД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

СУУРЬ ТҮВШИН

Эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй шинэчлэх, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа 7 журмын төслийг чиглэл хариуцсан нэгж боловсруулж шинэчлэн батлуулахаар олон нийтээс санал авахаар гаалийн байгууллагын цахим санд байршуулсан, ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа гаалийн газар, хороодоос санал авч нэгтгэснийг хууль тогтоомжид нийцсэн эсэхийг ХХ-ээс хянасан бөгөөд Мэргэжлийн зөвлөлд танилцуулахад бэлэн болсон.

Мөн ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн зарим журам зааврыг шинэчлэн боловсруулах, хүчингүй болгуулах ажлын хүрээнд тус хэлтсээс захиргааны 7 шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн ажилласан.

ХЭРЭГЖИЛТ

Эрх зүйн актад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ дараах төрлийн судалгаануудыг хийсэн /хавсаргав/. Үүнд:

1.Гаалийн ерөнхий газрын даргад хуулиар нийтээр дагаж мөрдөх эрх олгосон хуулийн заалтын судалгаа. /7/

2.Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх шинжтэй эрх зүйн актын жагсаалт, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болон ЗХХАУНС-д бүртгүүлсэн байдлын судалгаа. /12 хуудас/

3.Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн актийн судалгаа. /44 хуудас/

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №А/23 тушаалаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн ахлагч, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Захиргааны хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн хэрэгжилтийг хангаж Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын судалгааг хийж гүйцэтгэн, холбогдох арга хэмжээ авах үүрэг бүхийн ажлын хэсэгт Гаалийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Тамираа гаалийн байгууллагыг төлөөлөн ажиллаж байна.

Гаалийн ерөнхий газар “Захиргааны хэм хэмжээний актын тухай” Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №03/729 албан бичиг, түүнд хавсаргасан “Захиргааны хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”/цаашид “удирдамж” гэх/-ийг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч судаллаа.

Удирдамжийн “Дөрөв”, “Тав” дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд тодорхой хугацаа олгогдсон байгаа тул холбогдох танилцуулгыг урьдчилсан байдлаар хүргүүлсэн. Үүнд:

Удирдамжийн “Нэг.Нийтлэг үндэслэл”-ийн хүрээнд,

Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан, хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх шинжтэй 36 эрх зүйн акт гаалийн харилцаанд хэрэгжиж байна.

Дээрх захиргааны актууд Гаалийн тухай хууль болон бусад хуулийг өөрчлөлтийг судалж тухай бүр боловсронгуй болгож байгаа.

Мөн түүнчлэн гаалийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангаж, Дэлхийн гаалийн байгууллагын санал, зөвлөмжийг тусган хэм хэмжээний акт батлан гаргахдаа судалж тухай бүр боловсронгуй болгож байна.

Иймд гаалийн харилцаанд хэрэгжиж байгаа Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байх хэм хэмжээний актад хамааруулах саналтай байна.

Удирдамжийн “Хоёр.Хуульд тусгах шаардлагатай зохицуулалт агуулсан хэм хэмжээ тогтоосон акт”-ын хүрээнд

Эрхлэх асуудлын хүрээ, үйл ажиллагаанд хамаарах актуудыг судлан үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хориглосон ямар нэгэн байдлаар хөндсөн агуулга бүхий заалттай зохицуулалт байхгүй байна гэж үзэхээр байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын бүрэн болох тогтоох эрх мэдэлд хамаарах заалтыг зөрчсөн гэж үзэхээр хэм хэмжээний акт батлагдаж байгаагүй байна.

Тус байгууллагаас захиргааны хэм хэмжээний акт батлахдаа гаалийн харилцаанд оролцогчдын харилцан тэгш эрхтэй гадад худалдаанд оролцох, тэдгээрийн эрх, эрх чөлөөг хангах зарчмыг баримтлан ажиллаж, хэм хэмжээний актын төсөл боловсруулах тухай бүр Захиргааны ерөнхий хуульд заасан “Нөлөөлийн шинжилгээ”-г зохион байгуулж байна.

Удирдамжийн “Гурав.Захиргааны хэмжээний улсын нэгдсэн санг цэгцлэх” хүрээнд,

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг шинэчлэн гаргах тухай” 3/77 тоот албан бичгээр ирүүлсэн 37 акт бүхий жагсаалтыг гаалийн байгууллагын эрхийн актын сантай тулгаж, нягтлан шалгасан.

Жагсаалтад дурдсан 37 захиргааны хэм хэмжээний акт нь гаалийн байгууллагын мэдээллийн санд байгаа эрхийн акттай тохирч байгаа талаар ГЕГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны 01/161 тоот албан бичгээр хариуг ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

2023 оны 12 сарын 14-ний байдлаар дээрх 37 захиргааны хэм хэмжээний актаас ГЕГ-ын даргын 2019 оны “Журам батлах тухай” А/226 (“Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”), 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/345 (“Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”) тушаалыг ГЕГ-ын даргын 2023 оны “Журам батлах тухай” А315 дугаар тушаалаар хүчингүй болгосон.

ГЕГ-ын даргын 2023 оны “Журам батлах тухай” А315 дугаар тушаалаар “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ыг шинэчлэн баталсан.

Удирдамжийн “Хүчингүй болгох шаардлагатай захиргааны хэм хэмжээний актын талаар авах арга хэмжээ”-ний хүрээнд,

Хүчингүй болгуулах, эсхүл “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сан”-д бүртгүүлээгүй нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт гаалийн байгууллагад байхгүй.

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын хуралдааны 2022 оны 55 дугаар тэмдэглэлийг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолыг удирдлага болгон ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 37 захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг саналын хамт ГЕГ-ын 2023 оны 05 дугаар сарын 10-ны 01/1740 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

ХҮРСЭН ТҮВШИН

Эрхзүйн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээгээр дараах нөхцөх байдал тогтоогдсоныг ГЕГ-ын даргын “Тайлан, судалгаа, бусад материал хүргүүлэх тухай” 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн №01/602 албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбатад хүргүүлсэн. Үүнд:

1.Гаалийн тухай хуулийн 267¹-6 дахь хэсэгт “Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг Засгийн газар батална.” гэж заасан нь Гааль, татварын ерөнхий газар 2016 онд татан буугдсанаас хойш энэ дүрэм батлагдаагүй байна.

2.Гаалийн тухай хуулийн 250.2 дахь хэсэгт “Барааг гаалийн хяналтын дор хүргэх арга хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.” гэж заасан нь энэ журам батлагдаагүй байна.

3.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын /хуучин нэрээр/ хилийн мэргэжлийн хяналтын албаны “улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх” чиг үүрэг гаалийн байгууллагад шилжсэн.

Үүнтэй холбогдуулан Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 19.2 дахь хэсэгт “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх **ариутгал, халдваргүйжүүлэлтийн журмыг гаалийн байгууллага тогтооно.**” гэсэн зохицуулалт орсон.

Хуулийн хэлтэс

Харин Монгол Улсын хилийн тухай хуулийн 29.9 дэх хэсэгт “..., **халдвар хамгаалал, ... хариуцах** чиг үүрэг бүхий Хилийн боомтын захиргааг Засгийн газар байгуулна.” гэж заасан.

Дээрх хуулиудад заасан чиг үүрэг одоогийн байдлаар давхардсан, аль байгууллага ариутгал, халдваргүйжүүлэлтийн журмыг батлах нь тодорхойгүй байх тул эрх зүйн давхардлыг арилгуулах шаардлагатай.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

Их тойруу 81/1, Утас/Факс: (976-11) 35 00 60,

И-мэйл: info@customs.gov.mn, Вэбсайт: www.customs.gov.mn

2024.02.16 № 01/602
танай _____-ны № _____-тТайлан, судалгаа, бусад материал
хүргүүлэх тухайСАНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ж.ГАНБАТ ТАНАА

Танай ирүүлсэн “Захиргааны хэм хэмжээний тухай” 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №03/729 албан бичгийг хүлээн авч судалж танилцлаа.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №А/23 тушаалаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн ахлагч, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Захиргааны хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн хэрэгжилтийг хангаж Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын судалгааг хийж гүйцэтгэн, холбогдох арга хэмжээ авах үүрэг бүхийн ажлын хэсэгт Гаалийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Тамираа оролцож байгаа бөгөөд удирдамжид заасан арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний дотор хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.

Үүнээс өмнө “Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн дагуу холбогдох танилцуулга, судалгаа, бусад материалыг албан бичигт заасан хугацаанд урьдчилсан байдлаар хүргүүлж байна.

Жич: “Ажлын хэсэг байгуулах тухай” Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №А/23 тушаалыг хүргүүлж байна.

Хавсралт 28 хуудастай.

ДАРГА



Р.ОТГОНЖАРГАЛ

1429567 0504

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЭРХ ОЛГОСОН ЗААЛТЫН СУДАЛГАА

№	Хуулийн зохицуулалт
1.	12 дугаар зүйл.Зөвлөгөө өгөх 12.1.Гаалийн байгууллага нь гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгч болох бөгөөд ийнхүү зөвлөгөө өгөх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
2.	14 дүгээр зүйл.Гаалийн статистикийн мэдээллийн төрөл, мэдээллийг гаргах аргачлал 14.3.Энэ хуулийн 14.2-т заасан үндэсний аргачлалыг гаалийн удирдах төв байгууллагын болон Үндэсний статистикийн хорооны дарга хамтран батална.
3.	14 дүгээр зүйл.Гаалийн статистикийн мэдээллийн төрөл, мэдээллийг гаргах аргачлал 14.4.Энэ хуулийн 14.1.2-т заасан статистикийн мэдээллийн аргачлал, үзүүлэлтийг Статистикийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
4.	15 дугаар зүйл.Гаалийн статистикийн мэдээллийг ашиглах 15.3.Энэ хуулийн 15.2-т заасан төлбөрийн хэмжээг тухайн мэдээллийг гаргаж өгөхөд шаардагдах зардлаас хэтрүүлэлгүйгээр гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.
5.	23 дугаар зүйл.Гомдлыг хянан шийдвэрлэх 23.1.Гаалийн байгууллага, албан тушаалтан нь энэ хуулийн 17.1-д заасан гомдлыг хянаж гаргасан шийдвэрээ гаалийн удирдах төв байгууллагын даргаас баталсан загварын дагуу бичгээр үйлдэнэ.
6.	24 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийх 24.3.Гаалийн хилээр нэвтрүүлэх зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан гаалийн бүрдүүлэлтийн журмыг энэ хуульд нийцүүлэн гаалийн удирдах төв байгууллагын дарга тусгайлан баталж болно.
7.	25 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийх газар, цаг 25.1.Гаалийн бүрдүүлэлтийг гаалийн байгууллага бүхий газарт, гаалийн удирдах төв байгууллагын даргаас тогтоосон цагт хийнэ.
8.	26 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн хураамж 26.2.Энэ хуулийн 26.1-д заасан хураамжийн хэмжээг үйлчилгээний зардлыг харгалзан гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.
9.	27 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримт 27.2.Энэ хуулийн 27.1-д заасан мэдээлэл, бичиг баримт гаргаж өгөх хугацааг гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.

10.	27 дугаар зүйл.Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримт 27.7.Мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн мэдээлэл, бичиг баримтыг хэвлэж эрх бүхий этгээдийн гарын үсгээр баталгаажуулна.
11.	29 дүгээр зүйл.Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт 29.2.Энэ хуулийн 29.1-д заасан бараанд гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд бүрдүүлж өгөх болзолтойгоор дараалал харгалзахгүй гаалийн бүрдүүлэлт хийнэ.
12.	29 дүгээр зүйл.Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт 29.3.Энэ хуулийн 29.1-д заасан барааг мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаргаж өгөх баталгааг бичгээр гаргана.
13.	36 дугаар зүйл.Ачааны манифест 36.2.Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
14.	55 дугаар зүйл.Барааг гаалийн байгууллагад мэдүүлэх 55.5.Гаалийн мэдүүлгийн маягтын загвар, түүнийг нөхөн бичих, шалгах зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
15.	67 дугаар зүйл.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага 67.2.Энэ хуулийн 67.1.4-т заасан санд байршуулах хөрөнгийн хэмжээг зуучлалын үйлчилгээнд хамаарах барааны хэмжээнээс хамааруулан гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно.
16.	67 дугаар зүйл.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага 67.3.Гаалийн зуучлагч болон бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд гаалийн байгууллага хяналт тавих бөгөөд гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
17.	68 дугаар зүйл.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн 68.1.Гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан иргэнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гэрчилгээ олгоно.
18.	71 дүгээр зүйл.Барааг олгох үндэслэл 71.1.3.гаалийн болон бусад татварыг төлсөн, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар гаргасан;
19.	79 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын төрөл 79.7.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын код, тухайн горимын дагуу шаардах мэдээлэл, бичиг баримтын жагсаалтыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
20.	138 дугаар зүйл.Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох

	138.4.Энэ хуулийн 138.1-д заасан зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зөвшөөрлийн хугацааг нь сунгах, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.
21.	139 дүгээр зүйл.Зөвшөөрөл эзэмших хүсэлт гаргах 139.1.14.гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Монгол Улсын Засгийн газраас баталсан тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт;
22.	220 дугаар зүйл.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх 220.5.Энэ хуулийн 220.1-д заасан барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
23.	222 дугаар зүйл.Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх 222.4.Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн болон шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
24.	230 дугаар зүйл.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийн тоо хэмжээ 230.1.Гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийн жагсаалт, тоо хэмжээг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
25.	232 дугаар зүйл. Гаалийн хяналтын нийтлэг үндэслэл 232.2.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батлах бөгөөд зарим бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогийг харгалзан тусгай журам тогтоож болно.
26.	232 дугаар зүйл.Гаалийн хяналтын нийтлэг үндэслэл 232.9.Гаалийн хууль тогтоомж зөрчсөн болон зөрчихийг завдсан үйлдлийн талаархи мэдээллийг гаалийн байгууллага төлбөртэй, эсхүл төлбөргүйгээр хүлээн авч нууцлалыг хадгалах бөгөөд энэхүү мэдээллийг хүлээн авах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
27.	236 дугаар зүйл.Гаалийн хяналтын бүс 236.6.Гаалийн хяналтын бүсийн журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална
28.	238 дугаар зүйл.Гаалийн хяналтад шаардагдах тайлан 238.1.Зуучлагч, тээвэрлэгч, түүнчлэн түр агуулах, гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь гаалийн байгууллагаас баталсан загварын дагуу тайлан гаргана.
29.	249 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалт 249.4.Гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалт хийх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
30.	250 дугаар зүйл.Барааг гаалийн хяналтын дор хүргэх

	250.2.Барааг гаалийн хяналтын дор хүргэх арга хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно. Тайлбар: Энэ журам батлагдаагүй байна.
31.	251 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах 251.3.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
32.	252 дугаар зүйл.Гаалийн хяналт хийхэд шинжээч томилох 252.8.Магадлан шинжилгээ хийх, шинжээч томилох, дүгнэлт гаргах журам, шинжээчид тавигдах шаардлагыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
33.	256 дугаар зүйл. Сорьц, дээж, загвар авах 256.7.Сорьц, дээж, загвар авах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
34.	261 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх 261.7.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд тэмдэглэгээ хэрэглэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
35.	262 дугаар зүйл.Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх 262.2.Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн удирдах төв байгууллагын болон Оюуны өмчийн газрын дарга нар хамтран батална.
36.	267¹ дүгээр зүйл. Гаалийн байгууллагын тогтолцоо 267¹.6.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг Засгийн газар батална. Тайлбар: Гааль, татварын ерөнхий газар татан буугдсанаас хойш энэ дүрэм батлагдаагүй байна.
37.	271¹ дүгээр зүйл. Гаалийн байгууллагын удирдлагын бүрэн эрх 271¹.1.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2711.1.16.улс хоорондын худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартын дагуу гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд гаалийн харилцаанд оролцогчид гаалийн итгэмжлэл олгох;
38.	286 дугаар зүйл.Гаалийн байгууллагын байршил, ажиллах цагийн хуваарь 286.1.Гаалийн удирдах төв байгууллагын дарга нь гаалийн байгууллагын байршил, ажиллах цагийн хуваарийг гадаад худалдаанд дэмжлэг үзүүлэх хэрэгцээг харгалзан тогтооно.
39.	286 дугаар зүйл.Гаалийн байгууллагын байршил, ажиллах цагийн хуваарь

	286.2.Хилийн боомт болон олон улсын нисэх буудал дээр байрлаж байгаа гаалийн байгууллагын ажиллах цагийн хуваарийг тухайн хилийн боомтын ажиллах цагийн хуваарьтай нийцүүлэн тогтооно.
40.	288 дугаар зүйл. Мэдээллийн систем, сүлжээ, технологи ашиглах 288.4.Гаалийн үйл ажиллагаанд оролцогчийн ашиглах мэдээллийн систем, технологид тавигдах шаардлага, ашиглах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
41.	298 дугаар зүйл. Хадгалах хугацаа дууссан барааг шийдвэрлэх 298.3.Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАР ТУХАЙ ХУУЛИАР ТУСГАЙЛАН
ЭРХ ОЛГОСОН ЗААЛТЫН СУДАЛГАА**

№	Хуулийн зохицуулалт
1.	21 дүгээр зүйл. Уялдуулсан систем 21.2.Барааг тодорхойлох, кодлох Уялдуулсан системд үндэслэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, үндэсний кодыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.
2.	23 дугаар зүйл. Барааны ангиллыг урьдчилан тодорхойлох 23.2.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИАР ТУСГАЙЛАН
ЭРХ ОЛГОСОН ЗААЛТЫН СУДАЛГАА**

№	Гаалийн тухай хуулийн зохицуулалт
	19 дүгээр зүйл.Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тавих шаардлага 19.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх ариутгал, халдваргүйжүүлэлтийн журмыг гаалийн байгууллага тогтооно.

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИАР ТУСГАЙЛАН
ЭРХ ОЛГОСОН ЗААЛТЫН СУДАЛГАА**

№	Гаалийн тухай хуулийн зохицуулалт
	14 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх 14.2.Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг Гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

**ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИАР ЭРХ ОЛГОСОН
ЗААЛТЫН СУДАЛГАА**

№	Хуулийн зохицуулалт
1	7 дугаар зүйл.Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс 7.3.Хувиргасан амьд организмаас гаралтай импортын хүнсний талаар хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хорио цээрийн хяналт шалгалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон биоаюулгүй байдлын асуудал эрхэлсэн байгууллага цахим хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛААР БАТАЛСАН
ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН, НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДӨХ ШИНЖТЭЙ
ЭРХ ЗҮЙН АКТЫН ЖАГСААЛТ, ТЭДГЭЭРТ ОРСОН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙГ ТУСГАСАН БОЛОН ЗХХАУНС-Д
БҮРТГҮҮЛСЭН БАЙДАЛ**

/Судалгаа/

2024 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

№	Огноо	дугаар	субъект	гарчиг	Гаальтай холбогдох зүйл, хэсэг, эсхүл товч утга, онцлог	Энэ тушаалаар хүчингүй болсон тушаал, тушаалын заалт	Энэ тушаалд Нэмэлт өөрчлөлт оруулсан тушаал	Энэ тушаалын зүйл, заалт, хавсралтыг хүчингүй болсон тушаал	ЗХХАУНС-д бүртгүүлсэн	
									огноо	дугаар
1	2008.09.10	536	ГЕГ	Журам батлах тухай	Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах журам	2002 оны 266-р тушаалыг хүчингүй болгосон.	2019 оны А/170 тушаалаар энэ тушаалын үндэслэх хэсэгт өөрчлөлт орсон		2008.09.22	2941
	2019.08.23	А/170	ГЕГ	Тушаалд өөрчлөлт оруулах тухай	Бараа тээврийн хэрэгслийг саатуулах журам баталсан тушаалын үндэслэх хэсэгт өөрчлөлт оруулсан	2008 оны 536-р тушаалын үндэслэх хэсэгт			2019.09.11	2941

2	2008. 10.06	618	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн хууль тогтоомж зөрчсөн болон зөрчихийг завдсан үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх журам" - 1, "Мэдээлэл бүртгэх маяг" - 2-р хавсралт	2000 оны 544-р тушаалыг хүчингүй болгосон.	2019 оны А/169 тушаалаар энэ тушаалын үндэслэх хэсэгт өөрчлөлт орсон		2008.10.20	2951
	2019. 08.23	А/169	ГЕГ	Тушаалд өөрчлөлт оруулах тухай	Гаалийн хууль тогтоомж зөрчсөн болон зөрчихийг завдсан үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх журам баталсан тушаалын үндэслэх хэсэгт өөрчлөлт оруулсан	2008 оны 618-р тушаалын үндэслэх хэсэгт			2019.09.11	2951
3	2008. 10.15	643	ГЕГ	Журам батлах тухай	"Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"	2007 оны 756-р тушаалыг хүчингүй болгосон.			2009.01.06	2979
4	2008. 10.17	660	ГЕГ	Журам батлах тухай	"Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам"	2006 оны 17-р тушаалыг хүчингүй болгосон			2009.01.06	2980
5	2008. 10.22	678	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн баталгаат агуулахын гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам"-1, "Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын ГБГХЖ"-2,		2011/254-р тушаалаар нэмэлт, 2012/А/205 тушаалаар 5 хавсралт нэмэлт орсон	2015 оны А/281-р 1-5-р хавсралтуудыг хүчингүй болсон. ГТЕГ-ын 2016/А/42-р 1,	2009.01.06	2984

					"Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын ГБГХЖ"-3, "Гаалийн баталгаат барилгын талбайн ГБГХЖ"-4, "Татваргүй барааны дэлгүүрийн ГБГХЖ"-5, "Гаалийн тусгай бүсийн ГБГХЖ"-6-р хавсралт		2012/A/69 2013/A/250-р 2014/A/102, 2023 оны A/679-р нэмэлт өөрчлөлт орсон	2, 3, 4, 5-р хавсралт хүчингүй болсон.		
	2023. 12.20	A/679	ГЕГ	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	6-р хавсралтаар батлагдсан "Гаалийн тусгай бүсийн горим хэрэгжүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулсан	208 оны 678-р тушаалын 6-р хавсралтаар батлагдсан журамд			Бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн	
6	2008. 10.30	679	ГЕГ	Журам батлах тухай	"Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх"-1, "Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх" -2, "Бараа шилжүүлэн ачих"-3-р хавсралт горим хэрэгжүүлэх журмууд				2009.01.06	2957
7	2008. 10.22	680	ГЕГ	Журам батлах тухай	"Барааг хүлээн авахаас татгалзах"-1, "Бараа устгах"-2, "Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг гаалийн хилээр нэвтрүүлэх"-3 горим хэрэгжүүлэх журмууд				2009.01.06	2985

	2023. 06.05	A/366	ГЕГ	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	"Бараа устгах горим хэрэгжүүлэх журам"-д	2008 оны 680-р тушаалын 2- р хавсралтаар батлагдсан журамд			2023.06.20	2985
8	2008. 11.11	735	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх журам"		2019 оны A/171 тушаалаар тушаалын үндэслэх хэсэгт өөрчлөлт орсон		2008.11.18	2964
	2019. 08.23	A/171	ГЕГ	Тушаалд өөрчлөлт оруулах тухай	Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх журам баталсан тушаалын үндэслэх хэсэгт өөрчлөлт оруулсан	2008 оны 735-р тушаалын үндэслэх хэсэгт			2019.09.11	2964
9	2008. 11.28	756	ГЕГ	Журам батлах тухай	"Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн тэмдэглэгээ хэрэглэх журам"				2008.12.01	2968
10	2009. 06.18	298/41	ГЕГ	Журам батлах тухай	"Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"				2009.06.29	3044
11	2009. 07.30	362	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам"	2002.09.03- ны 454-р тушаалыг хүчингүй болгосон.	2017 оны A/285-р тушаалаар өөрчлөлт /3 дахь хэсэг/ орсон		2009.08.06	3069

	2017. 12.19	A/285	ГЕГ	Журамд өөрчлөлт оруулах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам"-ын хавсралтын Гурав дахь хэсгийг өөрчилсөн	2009 оны 362-р тушаалд өөрчлөлт				3069
12	2013. 09.26	A/199	ГЕГ	үйлчилгээний хураамжийн хэмжээ тогтоох тухай	"Үйлчилгээний хураамжийн хэмжээ"-1, "Гаалийн төв болон салбар лабораторийн шинжилгээний хураамжийн хэмжээ"- 2-р хавсралт	2008/673, 2009/181, 361, 2010/402, 2011/293, 2013/A/83-р тушаалыг хүчингүй болгосон	2015/A/166, 2018/A/29-р тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон, 2022 оны A/64-р тушаалаар 2 хавсралтыг хүчингүй болгосон	2022 оны A/64-р тушаалаар 2 хавсралтыг хүчингүй болгосон	2013.10.21	3409
	2018. 02.05	A/29	ГЕГ	Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	2013 оны A/199 тушаалын 1 хавсралтаар батлагдсан "Гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамжийн хэмжээ"- ний 5 дахь хэсгийн "шимтгэл" гэснийг "хураамж" гэж өөрчилсөн	2015 оны "Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" A/166-р тушаалыг хүчингүй болгосон.	2013 оны A/199-р тушаалын 1-р хавсралтад өөрчлөлт оруулсан.		2018.02.14	3409
	2022. 05.06	A/64	ГЕГ	Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай	"Гаалийн төв лаборатори болон гаалийн салбар лабораторийн шинжилгээний хураамж"	2013 оны A/199-р тушаалын 2-р хавсралтыг хүчингүй болгосон			2022.05.25	3409

13	2016. 02.24	A/40	ГТЕГ	Журам батлах тухай	"Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах ГБГХЖ"-1, "Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах ГБГХЖ" - 2, "Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах ГБГХЖ"-3, "Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах ГБГХЖ" -4, "Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах ГБГХЖ"-5-р хавсралт	2008/676, 2009/363, 2010/330, 2011/254, 2012/136, A/67, A/221, A/205, A/69, A/235, 2013/A/77, A/250, 2014/A/89, A/131, 2015/A/13, A/209, 2015/A/263, A/283-р тушаалыг хүчингүй болгосон.		2016.03.09	3617
14	2016. 02.24	A/41	ГТЕГ	Журам батлах тухай	"Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах ГБГХЖ" - 1, "Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах ГБГХЖ" - 2, "Барааг хилийн чанадад боловсруулах ГБГХЖ" - 3, "Барааг хилийн чанадад буцаан гаргах ГБГХЖ" - 4-р хавсралт	2008/677, 2009/363, 2011/254, 2015/A/106, A/189, A/285-р тушаалыг хүчингүй болгосон		2016.03.10	3620
15	2016. 11.29	A/62	ГЕГ	Заавар батлах тухай	"Бүрэн буюу бүрэн бус суудлын автомашин, суудлын автомашины кузовыг тодорхойлон ангилах заавар"	2006 оны 02-р тушаалыг хүчингүй болгосон.		2017.01.30	3688

16	2016. 12.12	A/79	ГЕГ	Журам батлах тухай	"ТИР конвенцийг хэрэгжүүлэх, ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих журам"	2003 оны 319-р тушаалыг хүчингүй болгосон.			2017.01.30	3690
17	2016. 12.12	A/80	ГЕГ	Журам батлах тухай	"Монгол Улсын хилээр нэвтрүүлэх цахилгаан эрчим хүчинд гаалийн хяналт тавих, бүрдүүлэлт хийх журам"	2007 оны 779-р тушаалыг хүчингүй болгосон.			2017.01.30	3689
18	2016. 12.12	A/81	ГЕГ	Журам батлах тухай	"Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тэдгээрийн түүхий эдийг МУ-ын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих тусгай журам"	2003 оны 348-р тушаалыг хүчингүй болгосон.			2017.01.30	3692
19	2016. 12.12	A/82	ГЕГ	Заавар батлах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийн Үндсэн маягт" - 1, "Нэмэлт маягт" - 2, "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийн хавсралт" - 3, "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар" - 4, "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар" - 5-р хавсралт	ГЕГ-ын 2010 оны 573, 2015 оны A/160, ГТЕГ- ын 2016 оны A/237-р тушаалыг хүчингүй болгосон	2019 оны A/250, 2022 оны A/346-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт		2017.01.30	3691
	2019. 11.14	A/250	ГЕГ	Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар"-т	2016 оны A/82-р тушаалаар батлагдсан зааварт			2019.11.25	3691

	2020. 08.14	A/153	ГЕГ	Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар"-т	2017 оны A/82-р тушаалаар батлагдсан зааварт			2020.08.14	3691
	2022. 12.19	A/346	ГЕГ	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар"-т	2016 оны A/82-р тушаалаар батлагдсан зааварт			2022.12.23	3691
20	2017. 06.23	A/52, A/148, A/123	ТЕГ, ГЕГ, ЦЕГ	Журам батлах тухай	"Тусгай хэрэгслийг үйлдвэрлэх, дуурайлган хийх, гадаад улсаас оруулж ирэх зөвшөөрөл олгох журам"	ТЕГ, ЦЕГ, ГЕГ-ын 2000 оны 272, 326, 344-р тушаалыг хүчингүй болгосон.			2017.06.27	3751
21	2018. 08.14	A/149	ГЕГ	Төлбөрийн хэмжээ тогтоох тухай	"Барааны экспорт, импортын статистик мэдээлэл" эмхтгэл, статистик мэдээлэл, лавлагаагаар үйлчлэхэд авах төлбөрийн хэмжээ	2013 оны A/114, 2018 оны A/127-р тушаалыг хүчингүй болгосон.			2018.08.23	3986
22	2019. 10.30	A/223	ГЕГ	Журам батлах тухай	"Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-1, "Зорчигчийн гаалийн мэдүүлгийн маягт"-2-р хавсралт	2008 оны 468, 632, 2012 оны A/139-р тушаалыг хүчингүй болгосон			2019.11.07	4511

23	2019.11.01	A/246	ГЕГ	Харьяа гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах	Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 1-р хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд болон идлэг шонхор - БУ боомтоор, 2-р хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйл - БУ, ЗҮ, АБ, СБ боомтоор	2011 оны 134-р тушаалыг хүчингүй болгосон			2019.11.18	4526
24	2019.12.04	A/275	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"	2016/A/236-р тушаалыг хүчингүй болгосон	2022 оны А/347-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт		2019.12.27	4589
	2022.12.19	A/347	ГЕГ	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	"Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-д	2019 оны А/275-д			2022.12.23	4589
25	2019.12.04	A/276	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн баталгаат агуулахын гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам"-1, "Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын ГБГХЖ"-2, "Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын ГБГХЖ" -3, "Гаалийн баталгаат барилгын талбайн ГБГХЖ"-4-р, "Татваргүй барааны	2016/A/42-р тушаалыг хүчингүй болгосон	2023 оны А/680-р тушаалаар 1, 2, 3, 4-р хавсралтыг хүчингүй болгосон		2019.12.27	4587

					дэлгүүрийн ГБГХЖ" - 5-р хавсралт					
	2023. 12.20	A/680	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн баталгаат агуулахын горим хэрэгжүүлэх журам"-1, "Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын ГХЖ"-2, "Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын ГХЖ" -3, "Гаалийн баталгаат барилгын талбайн ГХЖ"-4-р хавсралт	2019 оны A/276-р тушаалын 1- 4-р хавсралтыг хүчингүй болгосон			Бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн	
26	2019. 12.04	A/281	ГЕГ	Журам батлах тухай	"Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам"	ГТЕГ-ын 2016 оны A/238-р тушаалыг			2019.12.25	4570
27	2019. 12.04	A/282	ГЕГ	Журам батлах тухай	"Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"	2016/A/43, 2018/A/110- р тушаалыг хүчингүй болгосон	2020 оны A/102, 2022 оны A/351-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт		2019.12.25	4571
	2020. 05.27	A/102	ГЕГ	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	"Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"- ын 5.1-дэх хэсгийг өөрчлөн найруулсан		2019 оны A/282-р тушаалд		2020.06.08	4571
	2022. 12.30	A/351	ГЕГ	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	"Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-д	2019 оны A/282-т			2023.01.10	4571

28	2020. 02.19	A/42	ГЕГ	Гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай	хилийн чанадад гаргах түүхий болон дулааны аргаар, эсхүл бүрэн боловсруулсан махны гаалийн бүрдүүлэлт				2020.03.13	4734
29	2021. 03.17	A/118	ГЕГ	Журам батлах тухай	"Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам"	2019 оны A/288-р тушаалыг хүчингүй болгосон			2021.04.13	5200
30	2022. 02.09	A/25	ГЕГ	Журам батлах тухай	"Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам"	2008 оны 692-р тушаалыг хүчингүй болгосон			2022.02.21	5720
31	2022. 08.31	A/145	ГЕГ	Жагсаалтыг шинэчлэн батлах тухай	БТКУС жагсаалт	2017/300, 2018/A/20, 2019/A/212, A/266, 2020/A/34, A/114, A/130, A/166, 2021/A/171, A/248-р тушаалыг хүчингүй болгосон	2022 оны A/275, A/287-р тушаалаар нэмэлт өөрчлөлт		2022.09.12	5939
	2022. 11.30	A/275	ГЕГ	Үндэсний кодоод оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай	БТКУС жагсаалтад	2022 оны A/145-р тушаалын хавсралтад			2022.12.09	5939

	2022. 12.06	A/287	ГЕГ	Үндэсний кодод оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай	БТКУС жагсаалтад	2022 оны A/145-р тушаалын хавсралтад			2022.12.09	5939
32	2022. 12.12	A/338	ГЕГ	Шалгуур батлах тухай	Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох тухай	2019 оны A/128-р тушаалыг хүчингүй болгосон			2022.12.23	6069
33	2022. 12.12	A/339	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн хяналтын бүсийн журам"	2019 оны A/294-р тушаалыг хүчингүй болгосон			2022.12.23	6070
34	2022. 12.14	A/341	ГЕГ	Журам батлах тухай	"Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"	2010 оны 388, 2014 оны A/53-р тушаалыг хүчингүй болгосон			2022.12.27	6082
35	2022. 12.19	A/344	ГЕГ	Журам батлах тухай	"Бүрдүүлэлтийн дараах шалгалтын журам"	2015 оны A/134-р тушаалыг хүчингүй болгосон			2023.01.03	6099
36	2023. 05.16	A/315	ГЕГ	Журам батлах тухай	"Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"	2019 оны A/226, 2022 оны A/345-р тушаалыг хүчингүй болгосон			2023.06.15	6252

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛААР БАТЛАГДСАН, НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН ЭРХИЙН АКТ

/ЗХХА/

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

№	Баталсан албан тушаалтан, огноо, дугаар	Захиргааны хэм хэмжээний актын агуулга	Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдсэн эсэх /бүртгэгдсэн тохиолдолд бүртгэлийн дугаар/	Ямар хуулиар тусгайлан эрх олгогдсон	Тушаалын үндэслэл болсон хуулийн зохицуулалт хүчин төгөлдөр эсэх болон үндэслэлийг өөрчлөх шаардлагатай эсэх	Захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж буй харилцааг хуульд тусгах шаардлагатай эсэх /тусгах тохиолдолд хуулийн томъёолол/
1	ГЕГ-ын дарга 2008.09.10 №536	1. Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах журам	№2941 2008.09.22	Гаалийн тухай хууль 251 дүгээр зүйл.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах 251.3.Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	Эрх зүйн актын давхардал, хийдэл, зөрчлийн судалгаагаар үндэслэх хэсгийг хуульд нийцүүлэн 2019 оны №А/170 тушаалаар өөрчилсөн	Хуульд тусгахгүйгээр энэ ЗХХА-аар зохицуулах боломжтой

2	ГЕГ-ын дарга 2008.10.06 №618	1. Гаалийн хууль тогтоомж зөрчсөн болон зөрчихийг завдсан үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх журам 2. Мэдээлэл бүртгэх маягт	№2951 2008.10.20	Гаалийн тухай хууль 232 дугаар зүйл.Гаалийн хяналтын нийтлэг үндэслэл 232.9.Гаалийн хууль тогтоомж зөрчсөн болон зөрчихийг завдсан үйлдлийн талаархи мэдээллийг гаалийн байгууллага төлбөртэй, эсхүл төлбөргүйгээр хүлээн авч нууцлалыг хадгалах бөгөөд энэхүү мэдээллийг хүлээн авах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	Эрх зүйн актын давхардал, хийдэл, зөрчлийн судалгаагаар үндэслэх хэсгийг хуульд нийцүүлэн 2019 оны №А/169 тушаалаар өөрчилсөн	Хуульд тусгахгүйгээр энэ ЗХХА-аар зохицуулах боломжтой
3	ГЕГ-ын дарга 2008.10.15 №643	1. Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журам	№2979 2009.01.06	Гаалийн тухай хууль 220 дугаар зүйл.Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын барааг гаалийн хилээр нэвтрүүлэх 220.5.Энэ хуулийн 220.1-д заасан барааг гаалийн хилээр нэвтрүүлэх журмыг гаалийн удирдах төв	хүчин төгөлдөр, өөрчлөх шаардлагагүй	Хуульд тусгахгүйгээр энэ ЗХХА-аар зохицуулах боломжтой

				байгууллагын дарга батална.		
4	ГЕГ-ын дарга 2008.10.17 №660	1. Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам	№2980 2009.01.06	Гаалийн тухай хууль 298 дугаар зүйл. Хадгалах хугацаа дууссан барааг шийдвэрлэх 298.3.Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална	хүчин төгөлдөр, өөрчлөх шаардлагагүй	Хуульд тусгахгүйгээр энэ ЗХХА-аар зохицуулах боломжтой
5	ГЕГ-ын дарга 2008.10.22 №678	1. Гаалийн баталгаат агуулахын гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам 2. Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам 3. Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын гаалийн	№2984 2009.01.06	Гаалийн тухай хууль 79 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын төрөл 79.7.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын код, тухайн горимын дагуу шаардах мэдээлэл, бичиг баримтын жагсаалтыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.	хүчин төгөлдөр, өөрчлөх шаардлагагүй	Хуульд тусгахгүйгээр энэ ЗХХА-аар зохицуулах боломжтой

		бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам 4. Гаалийн баталгаат барилгын талбайн гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам 5. Татваргүй барааны дэлгүүрийн гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам 6. Гаалийн тусгай бүсийн гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам				
	ГЕГ-ын дарга 2008.10.30 №679	1. Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горим хэрэгжүүлэх журам 2. Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горим	№2957 2009.01.06	Гаалийн тухай хууль 79 дүгээр зүйл.Гаалийн бүрдүүлэлтийн горимын төрөл 79.7.Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх журам, горимын код, тухайн горимын дагуу шаардах	хүчин төгөлдөр, өөрчлөх шаардлагагүй	Хуульд тусгахгүйгээр энэ ЗХХА-аар зохицуулах боломжтой

		хэрэгжүүлэх журам 3. Бараа шилжүүлэн ачих горим хэрэгжүүлэх журам		мэдээлэл, бичиг баримтын жагсаалтыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.		
2	Төрийн хэмнэлтийн тухай хууль	2022-04-29		22.3. Энэ хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	Гаалийн байгууллага Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр Гаалийн ерөнхий газрын даргын албан даалгавар боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: 1.Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороодын санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн албан хаагчдад 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага, акт болон Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зэрэг чиглэлээр заавар, зөвлөмж өгөхөөр Гаалийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай хамтран цахим сургалт зохион байгуулсан. 2.Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, харьяа газар, хороодод хуваарилсан төсвийг дахин хуваарилах, тэвчиж болох урсгал зардлыг бууруулах зэрэг зохицуулалтыг хийн ажиллаж байна.

					3.Байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлыг бууруулах чиглэлээр нөөцлөх шаардлагатай бараа, материалыг их хэмжээгээр бэлтгэн нөөцлөхгүй байх, худалдан авалт хийхгүй байх зэргээр зардлыг хэмнэн ажилласан.
3	Төсвийн тухай хууль	2011.12.23	2011.12.23		Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр батлагдсан Гаалийн ерөнхий газрын даргын “Албан даалгавар” болон “Гаалийн байгууллагын урсгал зардлын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийх зөвлөмж”-ийн хэрэгжилтийг ханган Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллын заавар, Сангийн сайдын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж, батлагдсан урсгал зардлын төсвийг хэмнэн ажиллаж байна.


БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ, ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ ЭДЛЭХ, ЭДГЭЭРТЭЙ ХОЛБОГДОХ ГОМДОЛ, САНАЛЫГ ШИЙДВЭРЛЭХТЭЙ ХОЛБОГДОЛТОЙ ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАВ . ҮҮНД:

2024 онд 53 төрлийн импортын горимоор гаалийн бүрдүүлэлт хийн 5652.96 сая ам.долларын статистик үнийн дүнтэй бараанд 2514.74 тэрбум төгрөгийн татвар ногдуулж ажилласан.

Үзүүлэлт	2023 он	2024 он	Өссөн, буурсан	
			Тоо	Хувь
Горим тоо	48	53	5	9.4
Мэдүүлгийн тоо	133,355	184,670	51,315	27.8
Барааны тоо	810,928	934,913	123,985	13.3
Статистик дүн сая ам.дол	4,277.59	5,652.96	1,375	24.3

Татварын дүн тэрбум төгрөг	2,196.35	2,514.74	318	12.7
Хураамж сая төгрөг	1,244.67	1,531.03	286	18.7

Нийт бүрдүүлэлтийн 0,9%-ийг хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдах бараа эзэлж байгаа бөгөөд үүнээс ОУ-ын гэрээний дагуу хийгдэж буй төслийн бараанд 401, 402, 507 горимын 6087 бүрдүүлэлт хийж 284,7 сая ам.долларын статистик дүн бүхий бараанаас 47,6 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 101,1 тэрбум төгрөгийн НӨАТ, 0,2 тэрбум төгрөгийн онцгой албан татварыг, ЗГ-ийн 157 дугаар тогтоолоор гаалийн бүрдүүлэлтийн 403 горимын 6465 гаалийн бүрдүүлэлт хийж 140,1 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 18,9 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 47,1 тэрбум төгрөгийн НӨАТ-ыг тус тус чөлөөлсөн байна.



Өмнөх оны мөн үетэй харьцуулах нийт хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан бараа 2287 бүрдүүлэлтээр өссөн дүнтэй байна

Хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан нийт барааны 48,5%-ийг ОУ-ын гэрээний дагуу хийгдэж байгаа төслийн бараа, 51,5%-ийг ЗГ тогтоолын дагуу 403 горимоор дотоодын хэрэглээнд зориулан оруулах бараа эзэлж байна.



Хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан барааны 51,5%-ийг засгийн газрын 157 дугаар тогтоолоор 403 горимоор гаалийн бүрдүүлэлт хийсэн бөгөөд 403 горимын нийт бүрдүүлэлтийн хамгийн их хувийг хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, онгоцны сэлбэг хэрэгсэл эзлэж байна.

Утсаар хүлээн авсан гомдол, мэдээллийн талаар

Тайлант хугацаанд тус төвийн гомдол, санал хүлээж авах 7000-1280 утсанд ирсэн дуудлаганаас 4785 дуудлагыг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Мөн бараагаа гаальд мэдүүлэх талаар болон гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллгаатай холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

ББ ГУБ-тай холбож өгнө үү гэсэн дуудлагад гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээр дамжуулан чатаар холбогдох талаар зөвлөж, шаардлагатай тохиолдолд утсаар холбож ажиллалаа.

Цахим хаягаар гомдол хүлээж авсан талаар:

2024 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар <https://mail.customs.gov.mn/> цахим хаягаар ирсэн 1007

Дуудлагын төрөл	Тоо	Хувь
Удаад байна, үнэлгээ хийж өгнө үү	1119	23.4
Лабораторын дүгнэлт оруулсан баталгаажуулж өгнө үү	148	3.1
Татвар, үнэлгээ өндөр гарсан	613	12.8
ББ ГУБ солих	320	6.7
Гомдол хэрхэн гаргах вэ	208	4.3
Мэдүүлэг засварт буцааж өгнө үү	313	6.5
Зөвлөгөө мэдээлэл өгсөн	28	0.6
1800-1281-с лавлах шаардлагатай	34	0.7
Бусад	2002	41.8
Нийт	4785	100

санал, хүсэлт, гомдол маргаан CERP програмд бүртгэн шийдвэрлэсэн байна.

1111 утсаар ирсэн гомдол хүлээж авсан талаар:

2024 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар Засгийн газрын 1111 утсаар ирсэн 35 гомдолгомдол хүлээн авснаас 30 гомдлыг шийдвэрлэн гомдол гаргагчид хариу өгсөн. 5 гомдол шийдвэрлэх шатанд явж байна.

18001281 утсаар ирсэн гомдол хүлээж авсан талаар:

2024 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 18001281 утсаар ирсэн тус төвийн үйл ажиллагаатай холбоотой 12 гомдол ирснийг хүлээн авч, хуульд тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.

Төрөл	Тоо	Хувь
Хүсэлт	484	48.10%
Гомдол	257	25.50%
Барааны ангилал, үнэлгээ /БТКУС-ын код. Гаалийн татвар/	238	23.60%
Гаалийн хяналт, бүрдүүлэлттэй хамааралтай /горим/	13	1.30%
Тариф, татвартай холбоотой /хөнгөлөлт, чөлөөлөлт/	8	0.80%
Санал	4	0.40%
Хаяг байршил, утасны дугаар, боомтын хуваарь	1	0.10%
Шүүмжлэл	1	0.10%
Гаалийн хорио цээртэй холбоотой	1	0.10%
НИЙТ	1007	100.00%

Бүрдүүлэлтийн цахим төвд хийгдэж байгаа импортын барааны гаалийн бүрдүүлэлтийг 71 гаалийн зуучлагч байгууллагын 332 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн харилцаанд оролцсон байна.

Гаалийн тариф татварын тухай хуулинд заасан шаардлага хангаагүй гаалийн мэдүүлгийг шалгаж импортын барааны гаалийн үнийг тодрхойлон 49.8 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт нэмж төвлөрүүлсэн.

СТАТИСТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЭР ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАВ. ҮҮНД:

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо	Мөрдөж эхэлсэн огноо	Хуулийн холбогдох заалт	Хэрэгжилтийн байдал
1	Статистикийн тухай хууль	1997.06.05	2005.07.01	5	- “Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл”-ийг 2023 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэлээр,

					2024 оны эхний 1, 2, 3, 4, 5 саруудын мэдээллийг сар бүр 16 хавсралтаар эрхлэн гаргаж байна. /Нийт 7 удаа/ Мөн экспорт, импортын гол нэрийн барааны мэдээг сарын эхний 15 хоногоор гарган цахимаар хүргүүлэн ажилласан. /5 удаа/ - “Гаалийн захиргааны статистикийн мэдээлэл”-ийг 2023 оны 12-р сар, 2024 оны эхний 1, 2, 3, 4, 5 саруудын байдлаар сар бүр 24 хавсралтаар эрхлэн гаргаж дотоод сүлжээнд байршуулан гаалийн байгууллагын дотор ашиглаж байна. /Нийт 7 удаа/
2	Статистикийн тухай хууль	1997.06.05	2005.07.01	6.2	- “Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл”-ийг 2023 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэлээр, 2024 оны эхний 1, 2, 3, 4, 5 саруудын мэдээллийг 16 хавсралтаар гарган сар бүрийн 5-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахимаар хүргүүлэн ажилласан. / Нийт 7 удаа/ - “Гаалийн захиргааны статистикийн мэдээлэл”-ийг 2023 оны 12-р сар, 2024 оны эхний 1, 2, 3, 4, 5 саруудын байдлаар гарган сар бүр 24 хавсралтаар эрхлэн гаргаж, 5 хавсралтыг Үндэсний статистикийн хороонд цахимаар хүргүүлэн ажилласан. /Нийт 7 удаа/
3	Гаалийн тухай хууль	2008.05.20	2008.07.01	13	- “Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл”-ийг Барааг тодорхойлох кодлох уялдуулсан системийн кодоор 16 хавсралтаар гаргадаг. Уг мэдээлэл гаргадаг үндсэн эх сурвалж нь гаалийн мэдүүлэг бөгөөд гаалийн бүрдүүлэлт хийсэн бараа, тээврийн хэрэгслийн гаалийн мэдүүлгүүдийг гаалийн байгууллага нь цахим сан үүсгэн хадгалдаг.
4	Гаалийн тухай хууль	2008.05.20	2008.07.01	14	- Гаалийн багууллага нь дараахи 2 төрлийн статистикийн мэдээллийг эрхлэн гаргадаг.

					1. “Барааны экспорт, импортын статистийн мэдээлэл” /Гадаад худалдааны барааны/ 2. “Гаалийн захиргааны статистикийн мэдээлэл” Статистикийн мэдээллийг эрхлэн гаргахдаа: - “Барааны экспорт, импортын статистийн мэдээлэл”-ийг гаргах аргачлалыг Үндэсний тооцооны систем, Төлбөрийн тэнцлийг боловсруулах аргачлал, Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай Киотогийн конвенцид нийцүүлэн НҮБ-аас гаргасан “Олон улсын барааны худалдааны статистик: ойлголт ба тодорхойлолтууд, 2010” зөвлөмжид тулгуурлан боловсруулж Үндэсний статистикийн хорооны дарга, Гаалийн ерөнхий газрын даргын хамтарсан 2015 оны А/14, А/15 тушаалаар баталсан . - “Гаалийн захиргааны статистикийн мэдээлэл”-ийг эрхлэн гаргахдаа 2023 оны 12 дугаар сарын 20-ны А/676 тушаалаар “Гаалийн захиргааны статистикийн мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах журам”-ыг баталж, баримтлан ажиллаж байна.
5	Гаалийн тухай хууль	2008.05.20	2008.07.01	15	- “Барааны экспорт, импортын статистийн мэдээлэл”-ийг 2023 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэл, 2024 оны эхний 1, 2, 3, 4, 5 сарын барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж гаалийн цахим хуудас www.gaali.mn/statistics сайтад байршуулан нийтэд тархааж байна. - “Гаалийн захиргааны статистикийн мэдээлэл”-ийг 2023 оны 12-р сар, 2024 оны эхний 1, 2, 3, 4, 5 саруудын байдлаар эрхлэн гаргаж гаалийн дотоод сүлжээ /СЕРП/-д байршуулан гаалийн байгууллагын системийн хэмжээнд ашиглаж байна.

6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн	2013.05.31	2013.05.31	15	- Монгол банкинд зорчигчийн хилээр нэвтрүүлсэн валют, банкнуудын зузаатгалтын мөнгө дэвсгэртийн мэдээллийг 2023 оны 12-р сар, 2024 оны 1, 2, 3, 4, 5-р сарын байдлаар нийт 6 удаа гарган цахимаар хүргүүлэн ажиллаж байна.
7	МУ-ын ерөнхийлөгчийн 2018.01.23-ны өдрийн 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”	2018	2018	Журмын 1 дүгээр хавсралтын 23-т	- “Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг мэдээллээр хангах журам”-ын дагуу ҮАБЗ-д 2024.01.01-ээс 2024.06.14-ний хооронд өдөр бүр /166 удаа/ гол нэрийн экспорт, импортын барааны мэдээллийг БТКУС-ийн кодоор гарган, цахимаар хүргүүлэн ажилласан.
8	ЭЗХЯ, Сангийн яаманд	2023.04.17		03/605	- Экспорт, импортын зарим барааны мэдээллийг 2024.01.01-ээс 2024.06.14-ний хооронд өдөр бүр /166 удаа/ хүснэгт болон инфографик байдлаар гарган ЭЗХЯ, Сангийн яаманд ГЕГ-ын ЗУГ-аар дамжуулан цахимаар хүргүүлэн ажиллаж байна. - Хөдөө аж ахуйн экспортын голлох бүтээгдэхүүний мэдээллийг 7 хоног бүрийн Мягмар гараг бүр /24 удаа/ гарган, ЭЗХЯ-нд цахимаар хүргүүлэн ажиллаж байна.
9	Улс оронд зудын байдал бий болж өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай	2024.02	2024.02		- Улс оронд зудын байдал бий болсонтой холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор 2024.02.19-өөс 2024.05.15-ны хооронд импортоор оруулсан малын тэжээлийн мэдээллийг БТКУС-ийн 10 кодоор, хил

	холбоотойгоор малын тэжээлийн мэдээлэл гаргаж явуулах Засгийн газрын хуралдаанаас гаргасан шийдвэр				нэвтэрсэн боомтуудаар гаргаж Онцгой байдлын газарт өдөр бүр /нийт 57 удаа/ цахимаар хүргүүлэн ажилласан.
10	МУ-ын Засгийн газрын 2024 оны 180 дугаар тогтоол	2024.05.01	2024.05.01		- Монгол улсад импортоор оруулсан гурилын мэдээлэл /улаанбуудайн гурилын төрөл, тоо хэмжээ, үнэ, хуулийн этгээдээр/-ийг 7 хоног бүр өссөн дүнгээр /8 удаа/ гарган ШӨХТГ-т цахимаар хүргүүлж байна. Уг мэдээг 2024.07.01 хүртэлх хугацаанд гаргаж хүргүүлнэ.
11	Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоол	2019	2019		- АМГТГ-т экспортын эрдэс бүтээгдэхүүний мэдээг сар бүр /6 удаа/ гарган, цахимаар хүргүүлэн ажилласан. - УУХҮЯ-нд эрдэс бүтээгдэхүүний 7 хоногийн мэдээг /24 удаа/ гарган, цахимаар хүргүүлэн ажиллаж байна. -
12	Хүнсний тухай хууль	2012.12.20		3.1.6	- Стратегийн хүнс /малын мах, сүү, тарианы үр, удаанбуудай, гурил, ундны ус/-ний импортын мэдээг сар бүр /6 удаа/ гарган ХХААХҮЯ-нд цахимаар явуулсан. - Хүнсний хувьсгалтай холбоотойгоор импортын хүнсний барааны мэдээллийг сар бүр /6 удаа/ гарган Гаалийн хорио цээрийн хэлтсээр дамжуулан Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлж байна.


АЛБАНЫ ЭРЭЛЧ НОХОЙ АШИГЛАХ ЧИГЛЭЭР ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАВ. ҮҮНД:

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо	Мөрдөж эхэлсэн огноо	Хуулийн холбогдох заалт	Хэрэгжилтийн байдал
---	--------------------	------------------	----------------------	-------------------------	---------------------

1.	Гаалийн тухай хууль	2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр	2008 оны 7 дугаар сарын 01	232.6.Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ техник, багаж хэрэгсэл, эрэлч нохой зэргийг ашиглаж болно.	Гаалийн ерөнхий газрын эрэлч нохойн сургалтын төв нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 13 газар хороодод 33 эрэлч нохой ажиллаж 14 зөрчил илрүүлсэн. Үүнд: 1-р сард БӨГГ 1 зөрчил, 3-р сард ЧХОУНБГГ-1 зөрчил, СэГГ- 1 зөрчил, 4-р сард ЗүГГ-2 зөрчил, СэГГ- 1 зөрчил, ДоГГ- 2 зөрчил 5-р сард ЗүГГ- 1 зөрчил, СэГГ- 3 зөрчил нийт 14 зөрчил илрүүлээд байна. Энэ нь 2023 оны эхний хагас жилийн байдалтай харьцуулан үзэхэд 55.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эрэлч нохдын зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх, гаалийн хяналт шалгалтад ашиглах эрэлч нохдыг нэмэх зорилгоор хориглосон хязгаарласан бараа бүтээгдэхүүн, хар тамхи мансууруулах бодис зэргийг таньж илрүүлэх анхан болон давтан сургалтуудыг 4 удаагийн сургалт явуулж 11 нохойг сургасан.
----	---------------------	------------------------------------	----------------------------	--	---

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЭР ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАВ. ҮҮНД:

Гаалийн байгууллагын веб сайтад нийтийн мэдээллийн ил байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг гаалийн байгууллагын www.customs.gov.mn вэб сайтын үндсэн болон дэд цэсэд тогтмол шинэчлэн байршуулж, байнга ил тод нээлттэй байлгах мэдээллүүдийн шилэн индексийн тайланг 2024 оны 05 сарын 09-ны өдөр Цахим хөгжлийн яамны Shilen.gov.mn сайтад үнэлүүлэхээр илгээж, 2024 оны 05 сарын 15-ны өдөр эхний байдлаар 74,68 хувьтай үнэлүүлээд байна.




Гаалийн ерөнхий газрын албан ёсны веб сайт /www.customs.gov.mn/

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд дараах мэдээллүүдийг тогтмол байршуулан ажилласан. Үүнд:

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “Нээлттэй мэдээлэл” заалтын дагуу байршуулсан мэдээлэл.

- Мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд Бидний тухай цэсний Бүтэц зохион байгуулалт дэд цэсэд гаалийн байгууллагын “Эрхэм зорилго”, “Үйл ажиллагааны “Стратегийн зорилго, зорилт”, “Тэргүүлэх чиглэл”, “Тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн”, “Бүтэц, зохион байгуулалт” тус тус 2024 онд шинэчилсэн байдлаар байршуулсан.


<https://customs.gov.mn/%d0%b7%d0%be%d1%80%d0%b8%d0%bb%d0%b3%d0%be-%d0%b7%d0%be%d1%80%d0%b8%d0%bb%d1%82/>




2. Ил тод байдал цэсний Хүний нөөцийн үйл ажиллагааны ил тод байдал дэд цэсэд “Хүний нөөцийн удирдлагын ил тод байдал”, “Сул орон тооны зар”, “Хүний нөөцийн стратеги хэрэгжилт”, “Хүний нөөцийн жагсаалт”, “Албан тушаалын тодорхойлолт” тус тус хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал байршуулсан.

Мэдээллийн шинэчилсэн байдал: 2024 оны 01, 02 дугаар улиралд хүний нөөцийн сул орон тооны зарыг зарласан хугацаанд нь нийтэд ил тод байршуулж, мөн гаалийн байгууллагын хүний нөөцийн стратеги хэрэгжилт, албан хаагчдын утасны жагсаалтыг шинэчлэн цэсэд байршуулсан.

<https://customs.gov.mn/%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d0%bd%d3%a9%d3%a9%d1%86%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b8%d0%bb-%d1%82%d0%be%d0%b4-%d0%b1%d0%b0%d0%b9%d0%b4%d0%b0%d0%bb/>







3. Ил тод байдал цэсний Төсөв санхүүгийн ил тод байдал цэсэд “Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл”, “Санхүүгийн тайлан”, “Төсөв гүйцэтгэл”, “Худалдан авах ажиллагаа”, “Шилэн данс”, “Бусад” тус тус төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд байршуулсан.

Мэдээллийн шинэчилсэн байдал: 2024 оны 1, 2 дугаар улирлын байдлаар “Төсөв гүйцэтгэл”-ийг сар бүр тогтмол, “Худалдан авах ажиллагаа”-ны тендерийн урилгыг зарласан хугацаанд байршуулсан. Мөн 2023 оны тендерийн урилга, түүний үр дүн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний тайлан, жилийн эцсийн тайланг 1 дүгээр улиралд байршуулсан.

<https://customs.gov.mn/%d1%82%d3%a9%d1%81%d3%a9%d0%b2-%d1%81%d0%b0%d0%bd%d1%85%d2%af%d2%af%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b8%d0%bb-%d1%82%d0%be%d0%b4%d0%b1%d0%b0%d0%b9%d0%b4%d0%b0%d0%bb/>



Хуулийн хэлтэс




4. Ил тод байдал цэсний Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал дэд цэсэд Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг тус тус байршуулсан.

Мэдээллийн шинэчилсэн байдал: 2024 оны Гаалийн байгууллагын төлөвлөгөө, шударга байдлын төлөвлөгөөг байршуулсан. Мөн 2023 гаалийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, АТГ-н биелэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, хэрэглэгчийн үнэлгээ, судалгааны тайлан, гаалийн ерөнхий газрын бүтэн жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээлэл, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан,



алсын хараа 2050 биелэлтийн тус тус 1 дүгээр улиралд байршуулсан.


<https://customs.gov.mn/%d0%be%d0%bb%d0%be%d0%bd-%d1%83%d0%bb%d1%81%d1%8b%d0%bd-%d0%b3%d1%8d%d1%80%d1%8d%d1%8d-%d0%ba%d0%be%d0%bd%d0%b2%d0%b5%d0%bd%d1%86/>

5. “Хууль эрх зүйн” цэсэд Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг байршуулсан.




<https://customs.gov.mn/%d0%be%d0%bb%d0%be%d0%bd-%d1%83%d0%bb%d1%81%d1%8b%d0%bd-%d0%b3%d1%8d%d1%80%d1%8d%d1%8d/>






6. Мэдээ мэдээлэл цэсний Цаг үеийн мэдээ, видео мэдээ дэд цэсэд мэдээлэл хариуцагчаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр, мэдээ мэдээллийг тогтмол байршуулдаг.

<https://customs.gov.mn/elementor-2695/>




7. Гаалийн байгууллагын чиг үүргийн хүрээнд статистик мэдээг сар бүр тогтмол шинэчлэн нүүр хуудасны цонхонд байршуулан ажиллаж байна.



8. “Хяналт, бүрдүүлэлт” цэсний “Гаалийн хяналт” дэд цэсийг 2020 оны 01 дүгээр улирлаас эхлэн шинэчилсэн. Тус цэсэд байрлах нийт 14 мэдээлэл, “Гаалийн хяналт” дэд цэсэд 4 мэдээлэл, Зөрчил дэд цэсэд 4 мэдээллийг тус тус байршуулсан.

Мэдээллийн шинэчилсэн байдал: 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар гаалийн хяналт цэсэд гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс, түр агуулах, гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч, хориглосон хязгаарласан бараа, зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, Зөрчил цэсэд 4 цонх шинээр нээж үндэсний аюулгүй байдал, мөнгө угаах терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх, хар тамхи мансууруулах бодис сэрэмжлүүлэг, зөрчлийн статистик тоон мэдээллийг байршуулсан.

<https://customs.gov.mn/%d0%b3%d0%b0%d0%b0%bb%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%85%d1%8f%d0%bd%d0%b0%bb%d1%82/>




9. Хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх “Монголын гааль” албан ёсны фейсбүүк хуудас, “MongolCustoms” твиттер нийгмийн сүлжээний хаягийг тус тус байршуулсан.

Мэдээллийн шинэчилсэн байдал: 2024 оны 2 дугаар улирлын байдлаар “Монголын гааль” албан ёсны фейсбүүк хуудас, “MongolCustoms” твиттер давхардсан тоогоор нийт 281 мэдээ, постер, рийл, видео нийтэлж байршуулсан.

<https://customs.gov.mn/%d1%85%d0%be%d0%bb%d0%b1%d0%be%d0%be-%d0%b1%d0%b0%d1%80%d0%b8%d1%85/>

Гаалийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллага болон олон нийттэй харилцахдаа Монгол улсын үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг үндсэн чиг шугамаа болгон ажиллаж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчилсан постер, цаг үеийн мэдээ, видео, видео мэдээг хийж Гаалийн байгууллагын “Монголын гааль” албан ёсны сошиал хаягаар олон нийтэд өдөр тутам мэдээлж хүргэсээр байна.



ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЭР ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАВ. ҮҮНД:

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо	Мөрдөж эхэлсэн огноо	Хуулийн холбогдох заалт	Хэрэгжилтийн байдал
1.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/	2019.06.06	2020.01.01	29.1.1.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах;	Гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн зөрчил мэдээлэл, эрсдэлтэй зорчигчийн сан болон бараа, тээврийн хэрэгслийн мэдээлэл, гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийх гаалийн болон бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, нотлох баримтыг бэхжүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд зөвлөмж илгээн телехяналтаар хянах боломж нөхцлийг хангахын тулд

					шалгуур үзүүлэлтүүдийг ажлын хэсгийн судалгааны үндсэн дээр боловсруулан батлуулж, Шуурхай хяналтын төвийн үйл ажиллагаанд ашиглаж байна. Шуурхай хяналтын төв Табльд дата анализ хийдэг платформыг ашиглан гаалийн автоматжуулсан КАИС системд ирүүлсэн гаалийн мэдүүлэгт батлагдсан шалгуур үзүүлэлтүүдээр өндөр эрсдэлтэй гэж сонгогдсон гаалийн мэдүүлэгт телекамерын системийг ашиглан давхар хяналт тавьж ажилласнаар нийт 54 мэдүүлэгт дүн шинжилгээ хийн, зөвлөмж илгээснээс хяналт шалгалтаар гаалийн үнэ, барааны нэр төрөл, тоо хэмжээ, ангилал худал мэдүүлж, татвараас зайлсхийхийг завдсан нийт 40 зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчлийг авч үзвэл Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.21-ийн 1.1, 1.2, 12 заалтуудын дагуу 218,592,867.4 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 109,207,353.5 төгрөгийн торгууль ногдуулсан арга хэмжээ авагдсан байна. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааны мэдээлэлд шалгуураар дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь үр дүнтэй байгаа тул цаашид зөвлөмжийн шалгуур үзүүлэлтүүдийг илүү оновчтой нарийвчлах, нэмэгдүүлэх тал дээр анхааран ажилаж байна.
2.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	1995.04.17	1995.04.17	12 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх 16 дугаар зүйл. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацаа	Гаалийн байгууллагад 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Засгийн газрын 11-11 төв, Гаалийн цахим бүрдүүлэлтийн төв, Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаар, харьяа гаалийн газар хороодоор дамжуулан нийт 4611 дуудлага бүртгэгдсэн байна. Үүний 3409 буюу 73.93% нь Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарт, 1007 буюу 21.83% нь цахим бүрдүүлэлтийн төвд, 135 буюу 2.93% нь Засгийн газрын 11-11 төвд, үлдсэн 60 буюу 1.31% нь гаалийн газар хороодод иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн лавлагаа, гомдол, мэдээлэл байна.

				19 дүгээр зүйл. Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих 20 дугаар зүйл. Өргөдөл, гомдолд судалгаа дүгнэлт хийх	Шуурхай хяналтын төв нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс харьяа гаалийн газар хороод болон Бүрдүүлэлтийн цахим төвд ирүүлсэн гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол, мэдээллийг бүрэн бүртгэлжүүлэх үүргийг албан бичгээр хүргүүлсэн ба энэ ажлын хүрээнд Гаалийн байгууллагын Захиргаа дотоод ажлын системийн “Дуудлагын төв” гомдол мэдээллийн програмд бүртгэлжүүлэх эрхийг тухайн чиг үүргийг хариуцсан албан тушаалтан бүрт нээж өгсөн. Гаалийн байгууллагатай холбоотой гомдлыг авч үзвэл Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөр дамжуулан 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 120, Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарт 69 гомдол, Бүрдүүлэлтийн цахим төвд- 257, харьяа гаалийн газар хороодод-27 гомдол хүлээн авч ЗДАС-ын “Дуудлагын төв” гомдол бүртгэлийн програмд бүртгэн, шийдвэрлэх нэгж, албан тушаалтанд цахимаар хуулийн хугацаанд шилжүүлэн ажилласан. Хүлээн авсан нийт гомдлыг холбогдох чиглэлээр нь задалж үзвэл: - Гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлттэй хамааралтай - 179 /37.84%/ - Гаалийн үнэ үнэлгээ, бичиг баримттай холбоотой – 144 /30.44%/ - Албан хаагчийн ёс зүйтэй холбоотой – 39 /8.25%/ - Гаалийн хорио цээртэй холбоотой - 11 /2.33%/ - Гаалийн зөрчилтэй холбоотой - 8 /1.69%/
--	--	--	--	---	---

					- Гаалийн сүлжээ, програм, тоног төхөөрөмжийн сааталтай холбоотой - 4 /0.85%/ - Бусад – 88 /18.60%/ гомдол тус тус эзэлж байна. Хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, хугацаа хэтэрсэн гомдол мэдээлэл байхгүй болно. Шийдвэрлэлт хуулийн хүрээнд шийдвэрлэгдсэн эсэх, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор Дотоод хяналт аюулгүй байдлын хэлтэсийн дарга болон ГУАБ-д тус програмд нэвтрэх эрхийг нээж өгсөн. 2024 оны эхний 5 сарын байдлаар ирүүлсэн санал, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийн, ЗУГ-т хүргүүлэн ажилласан.
--	--	--	--	--	---

---oOo---

2.2.УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлнэ.

СУУРЬ ТҮВШИН

УИХ-ын тогтоол 4, ҮАБ-ын зөвлөмж 1, ЗГ-ын тогтоол 16, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 8, ЗГ-ын албан даалгавар 2, нийт 31 тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн 8 удаагийн хэрэгжилтийг тус тус гарган Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар ахлах мэргэжилтэн З.Баянмөнхөд цахимаар тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

ХЭРЭГЖИЛТ

Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 29 дугаар тушаалаар Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтад өөрчлөлт орж Хуулийн хэлтсийн чиг үүрэгт “УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх” арга хэмжээ 2023 оны 03 дугаар сараас нэмэгдсэн. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон тус журмын нэгдүгээр хавсралт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа”-г тус тус үндэслэн тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан байна. Тус ажлын хүрээнд ГЕГ-т хамаарах тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг СЯ-д хүргүүлэн ажилласан.

ХҮРСЭН ТҮВШИН

Тайлант хугацаанд УИХ-ын тогтоол - 4, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж - 1, Засгийн газрын тогтоол - 18, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл - 10, Засгийн газрын албан даалгавар - 2, нийт 33 тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг

2024.01.31-нд 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт;

2024.03.05-нд 2-р сарын хэрэгжилт;

2024.04.04-нд 3-р сарын хэрэгжилт;

2024.05.06-нд 4-р сарын хэрэгжилт;

2024.06.05-нд 5-р сарын хэрэгжилтийг тус тус гарган Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар ахлах мэргэжилтэн З.Баянмөнхөд цахимаар /99010806/ цахимаар буюу bayanmunkh_z@mof.gov.mn хаяг руу тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Жагсаалтыг хавсралтаар оруулав.

---oOo---

ГЕГ-ЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

2024.06.25

№	Арга хэмжээ	Биелэлт 2024 оны эхний хагас жил
Монгол Улсын хууль		
УИХ-ЫН ТОГТООЛ		
1	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-06-17 Дугаар 2022 №36 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530824651591	5/и. улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх замаар хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:) Гаалийн байгууллагын хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүйн үзүүлэлт болох нян судлал, хими хор судлал болон ургамал хорио цээрийн магадлан шинжилгээг дараах лабораториуд хийж гүйцэтгэж байна. Үүнд: - ЗУГГ-ын итгэмжлэгдсэн салбар лаборатори (итгэмжлэлийн эрх: 2022-2026он) - СЭГГ-ын салбар лаборатори Эдгээр салбар лабораториуд нь АХБ-ны санхүүжилтээр нийлүүлэгдсэн өндөр мэдрэмжит тоног төхөөрөмжийг хүлээн авч ашиглалтад оруулж, шинжилгээний нэр төрөл, арга аргачлын нэвтрүүлэхээр ажиллаж байна. -Гаалийн төв лаборатори болон ЧХОУНБГГ, БӨГГ, ДоГГ, Увч аймгийн Боршоо боомтуудад хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох магадлан шинжилгээг хийхээр тоног төхөөрмж захиалан, нийлүүлж, албан хаагчдийг сургах ажил хийгдэж байна. Гэвч боловсон хүчин дутагдалтай хэвээр байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар лабораторийн шинжилгээнд 532,8 мян.тн, 6.355.978 ширхэг, 54 хайрцаг бараа бүтээгдэхүүнээс 12118 удаа 27,7 мян.кг бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулсан байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бараа, бүтээгдэхүүнээс 61946 үзүүлэлтээр шаардлага хангаж, 106 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна. Лабораторийн шинжилгээний төлбөр болох 485,4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн ба Улсын Мал эмнэлгийн лаборатори, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм шинжлэх лабораторийн шинжилгээнд хамруулсан барааны төлбөр ороогүй болно.Лабораторийн шинжилгээт хяналтад нийт хамрагдсан бүтээгдэхүүний /532,8 мян.тн буюу 0,03 тн/ 0,06 хувь дээжийг шинжилсэнээс 61946 үзүүлэлт буюу 99.8 хувь шаардлага хангаж,106 үзүүлэлт буюу 0.2 хувь нь шаардлага хангахгүй дүнтэй гарсан.
2	ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-12 Дугаар 2023 №06 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532717054541	1.1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд экспортод гаргах нүүрсийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн цахим системээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх, экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаатай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг баталж, мөрдүүлэх; Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, түүний хэрэгжүүлэх тогтоол, шийдвэрийн дагуу гаалийн лаборатори нь магадлан шинжилгээнд хамрагдаж буй уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гэрээг "Гэрээ бүртгэлийн нэгдсэн систем"-д бүртгэн, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд 100 хувь ашиглалтад оруулан, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. Тайлант хугацаанд Гаалийн төв лаборатори нь гэрээ бүртгэлийн системд бүртгэгдсэн уул уурхайн бүтээгдэхүүн болох нүүрсний 2028 дүгнэлт, 1089 эрдэс түүхий эд (зэс, мөнгө, хар тугалга, гянтболд, молебден, цайрын баяжмалууд, жонш, төмрийн хүдэр баяжмал, манганы хүдэр)-ийн дээжинд магадлан шинжилгээ хийж, барааны ангиллын кодыг тодорхойлсон дүгнэлт гаргасан байна. ГЕГ, ТЕГ болон ГТСМТТ УҮГ хамтран "Гааль, татварын автомат бүрдүүлэлт"-ийн системд Гэрээ бүртгэлийн системийг шинээр хөгжүүлж бүрэн дуусгасан. Дээрх системд гадаад болон дотоод худалдааны гэрээ, боловсруулах, баяжуулах гэрээ зэрэг ашигт малтмалын бүх төрлийн гэрээг бүртгэх боломжийг бүрдүүлсэн. Мөн ГБНС-д бүртгэгдсэн дотоод гэрээг цахим төлбөрийн баримтын системтэй холбож, төлбөрийн баримтыг цахимаар үйлдэх боломжтой болгосон. Сангийн сайдын 2023.04.17-ны өдрийн А/89

			дугаартай тушаалаар батлагдсан “Бараа, бүтээгдэхүүн, ашигт малтмалыг үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импортын үе шат бүрээр мэдээллийн нэгдсэн санд бүртгэх журам”-ын дагуу экспортлогч нар эрдэс бүтээгдэхүүнийг хилээр гаргахдаа ТЕГ-ын хянаж, баталгаажуулсан гэрээг үндэслэн гаалийн байгууллагад мэдүүлдэг бөгөөд дээрх гэрээний тоо хэмжээний хасалт нь экспортын гаалийн мэдүүлгийг үндэслэн хийгддэг. ТЕГ-аас хянаж, баталгаажуулсан дээрх гэрээг гаалийн байгууллага экспортын гаалийн бүрдүүлэлтэд гэрээ бүртгэлийн системээс шууд татан ашиглаж байна.	
	1.2.биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг баталж, шаардлагатай дэд бүтэц /итгэмжлэгдсэн лаборатори, агуулах, терминал, тээвэр логистикийн төв/-ийг бий болгох;	БТКУС-ийн Зүйл 26.01, 2701, 27.02-т хамаарах төмрийн хүдэр, төмрийн баяжмал, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнүүд биржийн арилжаагаар арилжаалагдаж байна. 2024.01.01-2024.06.19-ны өдрийн хоорондох хугацааны экспортын барааны гаалийн бүрдүүлэлтийн мэдээгээр БТКУС-ийн Зүйл 26.01-д хамаарах төмрийн хүдэр болон баяжмалын нийт мэдүүлгийн 1.5%, Зүйл 27.01, 27.02-т хамаарах нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний 19.4% нь тус тус биржийн гэрээтэй мэдүүлэг эзэлж байгаа бөгөөд хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг хянасан байна.-БАҮХ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай 223 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолын дагуу цахим арилжаагаар экспортод гаргах нүүрсийг 2023.01.17-ны өдрөөс эхлэн Гашуунсухайт дахь Чингэлэг тээврийн терминал гаалийн хяналтын бүсээр дамжуулан гаргаж байна. 2024.01.01-ний өдрөөс 2024.06.18-ны өдрийн байдлаар нээлтэй цахим арилжаагаар худалдаалсан: -Эрдэнэс тавантолгой ХК-ийн 44 гэрээний 5,296,808.35 тн; -Энержиресурс ХХК-ийн 189 гэрээний 2,741,849.88 тн; -Хангад-Эксплорэйшн ХХК /ГХО/ -ийн 13 гэрээний 165,663.60 тн; -Тавантолгой ХК-ийн 4 гэрээний 309,346.1 тн нүүрсийг тус тус Гашуунсухайт боомт дахь Чингэлэг тээврийн терминал гаалийн хяналтын бүсээр дамжуулан гаргасан байна.		
	1.3. уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах.	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, түүний хэрэгжүүлэх тогтоол, шийдвэрийн дагуу гаалийн лаборатори нь магадлан шинжилгээнд хамрагдаж буй уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гэрээг “Гэрээ бүртгэлийн нэгдсэн систем”-д бүртгэн, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд 100 хувь ашиглалтад оруулан, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. Тайлант хугацаанд Гаалийн төв лаборатори нь гэрээ бүртгэлийн системд бүртгэгдсэн уул уурхайн бүтээгдэхүүн болох нүүрсний 2028 дүгнэлт, 1089 эрдэс түүхий эд (зэс, мөнгө, хар тугалга, гянтболд, молебден, цайрын баяжмалууд, жонш, төмрийн хүдэр баяжмал, манганы хүдэр)-ийн дээжинд магадлан шинжилгээ хийж, барааны ангиллын кодыг тодорхойлсон дүгнэлт гаргасан байна. Биржийн гэрээг "Гэрээ бүртгэлийн нэгдсэн систем"-д оруулах, экспортын гаалийн мэдүүлэгт "Биржтэй эсэх" мэдээллийг оруулах боломжтой болгон Гаалийн автоматжуулсан мэдээллийн КАИС, СЭПС, Гааль.мн системүүдэд хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн.		
3	НҮҮРСНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААРХ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАНТАЙ	1/г. г/ Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Монголбанк болон холбогдох төрийн байгууллагуудын нүүрсний тээвэрлэлт, экспорт, үнийн талаар гаргаж байгаа статистик мэдээллийн зөрүүтэй байдлыг судлан үзэж, бодитой мэдээлэл гаргах чиглэлээр анхаарч ажиллах;	Монгол Улсын Их Хурлын 2022.06.10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэгтэй хянан шалгах түр хороо байгуулагдсантай холбогдуулан ЗТГ-аас ирүүлсэн дотоод зурвасыг үндэслэн нүүрсний тээвэрлэлттэй холбоотой мэдээллийг бэлтгэж, дотоод зурвасаар, файлаар тухай бүр хүргүүлсэн. Экспортын барааны гаалийн үнийн аргын хувьд хийгдсэн судалгаагаар хэлцлийн үнийн аргаар үнэлсэн 262200 бичлэг, 4 аргаар 72689 бичлэг байгаа нь хэлцлийн үнийн аргаар 78.3 хувийг үнэлсэн байна.	

	ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-19 Дугаар 2023 №08 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532690010311			
4	ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-12-07 Дугаар 2023_108	1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татварыг хэсэгчлэн төлөх, хугацааг сунгах асуудлыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлыг судалж, холбогдох төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татварыг хэсэгчлэн төлөх, хугацааг сунгах асуудлыг талаар чиглэл ирээгүй тул 2024 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт байхгүй болно.	
УИХ-ын Байнгын хорооны тогтоол				
1	Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ	1.6/.Экспортод гаргах махыг тухайн аж ахуйн нэгжийн мах боловсруулах үйлдвэрийн газар байрлаж байгаа орон нутгийн гүний гаалийн хяналтад ачилт хийлгэж, гаалийн бүрдүүлэлтийг газар дээр хийх замаар гаалийн хяналтын үйлчилгээг сайжруулах;	Гадаад худалдааг хөнгөвчлөх Засгийн газрын 178 дугаар тогтоолын хүрээнд үйлдвэр байрлаж буй гаалийн газар хороодоос экспортод гарч буй мах, махан бүтээгдэхүүнээс дээж авч Export.mofa.gov.mn цахим нэгдсэн системээр итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож гаалийн мэдээллийн системрүү дэмжуулан мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ 2-4 цаг, өдөртөө шийдвэрлэгдэж байна. 2024 оны эхний улирлын байдлаар БНХАУ-д 3853,5тн адууны мах, 6426,5тн дулааны аргаар чанаж боловсруулсан үхэр, хонь, ямааны мах,7177,5тн хонь, ямааны Иран, Ирак, Азербейжын, Узбекистан, Вьетнам улсад тус тус экспортлоход хяналт шалгалт хийсэн. Махны экспортод тавих гаалийн хяналт шалгалтыг сайжруулах, хил дээр хийх гаалийн хяналт, шалгалтын цаг хугацааг бууруулах, экспортыг дэмжих зорилгоор махыг тухайн аж ахуйн нэгжийн мах боловсруулах үйлдвэрийн газар байрлаж байгаа орон нутгийн гүний гаалийн хяналтын дор ачилт хийлгэж, гаалийн бүрдүүлэлтийг хийж байх асуудлыг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Дээрх шийдвэрийг үндэслэн Гаалийн тухай хуулийн 2711дүгээр зүйлийн 2711.1.9-д “харьяа гаалийн байгууллагын хариуцах хяналтын нутаг дэвсгэрийг тогтоох, тэдгээрийн эрх хэмжээг тодорхой бараа, тээврийн хэрэгсэл болон гаалийн бүрдүүлэлтийн горимоор хязгаарлах” гэж заасныг үндэслэн ГЕГ-ын даргын Гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай 2020 оны А/42 дугаар тушаалыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020.03.1-ны өдрийн 4734 дугаарт бүртгүүлэн, нийтээр дагаж мөрдөж байна.	

		1.7/. Хилийн чанадад гаргах түүхий болон дулааны аргаар эсхүл, бүрэн боловсруулсан махыг тээвэрлэхэд гаалийн байгууллагаас олгох итгэмжлэлд тавигдах шалгуур тодорхойгүй байдаг тул гаалийн байгууллагаас итгэмжлэл олгодоггүй болгох;	ЗГ-н 2003 оны 173-р тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Амьтан, ургамал,түүхий эд,бүтээгдэхүүнд экспорт,импортын гэрчилгээ олгох журам”-н 2.1.4. дэх заалт “Мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн лабораторийн шинжилгээний дүн” гэж заасны дагуу Хилийн чанадад гаргах түүхий болон дулааны аргаар эсхүл,бүрэн боловсруулсан мах,богийн болон адууны ясгүй түүхий хөлдүү махыг экспортлоход зөвхөн мал эмнэлэгийн лабораторийн шинжилгээг үндэслэнэ.Ө/Х: гаалийн лабораторийн магадлан шинжилгээ шаарддаггүй,2024 онд гаалийн төв болон салбар лабораториудын манадлан шинжилгээнд дээрх малын гаралтай бүтээгдэхүүн хамрагдаагүй болно. БНХАУ-д экспортолж буй адууны мах,дулааны аргаар чанаж боловсруулсан үхэр,ямаа,хонины маханд хоёр улсын хооронд байгуулсан протоколын дагуу зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх шардлагыг хангуулан ажиллаж байна. Түүхий мах болон дулааны аргаар боловсруулсан эсхүл бүрэн боловсруулсан махыг хил дээр буулгаж,нэг бүрчлэн шалгахад цаг хугацаа,зардал их шаардагдахаас гадна нь хадгалалт, тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаарддаг, түргэн муудаж, гэмтдэг бараа тул чанар,эрүүл ахуйд өөрчлөлт орж болзошгүй байдаг.Гүний гаалийн байгууллагад гаалийн бүрдүүлэлт хийлгээд хил рүү явж байгаа бараа буюу мах нь ГтХ-н 188-р зүйлд заасан барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд хамаарна. ГтХ-н 194.2-т дотоодод дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулах барааг гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэхээр заасан тул гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгчийн битүүмжлэлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн хилийн гаалийн хяналтанд хүргүүлдэг. ГтХ-н 2711.1.16-д” улс хоорондын худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартын дагуу гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд гаалийн харилцаанд оролцогчид гаалийн итгэмжлэл олгох” гэж заасныг үндэслэн ГЕГ-н даргын 2022 оны А/338 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг баталж,нийтээр дагаж,мөрдөж байна.	
		1.9/. 2021 оноос богийн болон адууны ясгүй түүхий хөлдүү махыг экспортын зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй экспортлодог болгох, экспортлох үхрийн махны тоо хэмжээг тухайн жилийн зуншлагын байдал, сүргийн бүтцийг харгалзан жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тогтоож байх.	Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ын 2.1.4. дэх заалт “Мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн лабораторийн шинжилгээний дүн” гэж заасны дагуу Хилийн чанадад гаргах түүхий болон дулааны аргаар эсхүл, бүрэн боловсруулсан мах, богийн болон адууны ясгүй түүхий хөлдүү махыг экспортлоход зөвхөн мал эмнэлэгийн лабораторийн шинжилгээг үндэслэнэ. Ө/Х: гаалийн лабораторийн магадлан шинжилгээ шаарддаггүй, 2024 онд гаалийн төв болон салбар лабораториудын магадлан шинжилгээнд дээрх малын гаралтай бүтээгдэхүүн хамрагдаагүй болно. Гадаа худалдааг хөнгөвчлөх экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Иран, Ирак, Азербейжын, Узбекистан, Вьетнам, Хонконг зэрэг улсад үхэр, хонь, ямааны мах түүхийгээр тухайн улсын шаардлагын дагуу ангилж савлан 2024 оны эхний улиралд 7177,5тн мах экспортлоход хяналт шалгалт хийсэн.	
2	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-12-28 Дугаар 2021 №06 ҮББХ	5. Хилийн боомтын менежмент, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төслүүд (Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Дорноговь аймгийн ханги боомт);	Гашуунсухайт боомт: БНХАУ-н ЗГ-н буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар Гашуунсухайт боомтод өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын барилгын ажил үргэлжилж байна.Нийт гүйцэтгэл 80%.Тус боомтод ухаалаг гарцын т.төхөөрөмж суурилуулах ажлыг бүтээн байгуулалтын барилгын ажилтай уялдуулан гүйцэтгэж байгаа ба зорчигч тээвэр болон ачаа тээвэр,эрдэс баялгийн хэсэгт у.гарцын т.төхөөрөмжүүдийг суурилуулж эхэлсэн.Нийт ажлын явц 55%-н гүйцэтгэлтэй байна. Ханги боомт: МУ-н ЗГ-н 2022оны 362-р тогтоолын дагуу ГЕГ-ын даргын 2023.11.20-ны өдөр удирдамж батлагдаж ажлын хэсэг байгуулагдсан. Ханги хилийн боомтод суурилуулах ухаалаг гарцын иж бүрдлийн байршлыг эцэслэн	

			шийдвэрлэж, үнийн санал ирүүлэх тухай албан бичгийг гүйцэтгэгч Мэйжүрмэнт ХХК-нд 2024.05.17-ны 01-1/1981 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗГ-н 2023оны 376-р тогтоолоор Ханги боомтын 33.5 га талбайд “Ханги олон төрөлт чингэлэг тээврийн терминал” байгуулж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгогдсон.Тус терминал нь Ханги хилийн боомтоос 1.4 км,БНХАУ-н хилийн зурвасаас 900 метрт байрлах ба нийт 33.5га талбайд авто машины Зорц болон 8.5км урт 3 салаа төмөр замтай,4500 орчим чингэлэг хадгалах,тээвэрлэх хүчин чадалтай юм.“Ханги эко логистик” ХХК-н 100%-н хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тус төслийн хүрээнд 2024.05.10-ний өдөр экспортын тээврийн ү.ажиллагааг эхлүүлсэн. Гашуунсухайт боомтоор экспортлож буй нүүрсний ангилал тодорхойлох,импортолж буй хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүйн үзүүлэлт шинжлэх лаборатори байгуулах хүрээнд дараах төслүүд хэрэгжээд байна. Үүнд: -Барилга(БНХАУ-ын санхүүжилт)баригдсан боловч лабораторийн зориулалтад нийцэхгүй байгаа тул хүлээн авах боломжгүй байна. -Тоног төхөөрөмж (улсын төсвийн хөрөнгө оруулалт)нүүрсний болон хүнсний бүтээгдэхүүний нян судлал,эрүүл ахуй,хорио цээрийн шинжилгээний зориулалттай нийт 43 үндсэн т.төхөөрөмж нийлүүлэгдсэн боловч барилгын асуудал шийдэгдээгүй байгаа тул сав балаа боодлоор түр хүлээн авсан.	
3	"Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын явцын талаар" 2023-06-09 Дугаар 2023 №06 ҮБХ	1.2/. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд зориулан буцаж гарах нөхцөлтэйгөөр импортоор оруулах техник тоног төхөөрөмжийн гаалийн нутаг дэвсгэрт түр горимд байх хугацааг тухайн үйлдвэр барьж дуусах хугацаагаар зохицуулахаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд зориулан буцаж гарах нөхцөлтэйгөөр импортоор оруулах техник тоног төхөөрөмжийн гаалийн нутаг дэвсгэрт түр горимд байх хугацааг тухайн үйлдвэр барьж дуусах хугацаагаар зохицуулахаар холбогдох хууль тогтоомжийг судлан цаашид авах арга хэмжээг тодорхой болгох шатанд явж байгаа болно.	
Засгийн газрын тогтоол				
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламж барих зориулалтаар улсын хилийн зурваст газар ашиглуулах тухай 2022.01.26 Дугаар 2022 53	3.Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих агуулахын барилга байгууламжийг барихад шаардлагатай зөвшөөрөл олгох, холбогдох шийдвэр гаргах асуудлыг шуурхай шийдвэрлэж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт тус тус үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 150 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Бичигт, Ханги боомт орчмын улсын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулах барих зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрсөн.Мөн газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулах барих төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулахыг УУХҮЯ-д үүрэг болгосон тул одоогийн байдлаар ААН-ээс дээрх асуудлаар гаалийн байгууллагад хандаагүй байна.	
2	Албан татвар хэсэгчлэн төлүүлэх тухай	2.Шивээхүрэн хилийн боомтын чингэлэгт тээврийн терминалын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор	1.Шивээхүрэн боомтын чингэлэг тээврийн терминалыг шинээр цахилгаанаар хангах зорилгоор МУ-н ЗГ-н 2022.09.05-ны өдрийн 335-р тогтоолыг үндэслэн Шивээхүрэн терминалын төслийн бүрэлдэхүүнд орсон“Нарийн сухайт эрчим” ХХК-н гүйцэтгэх 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам,110/35 кВ-н	

	2022-09-05 Дугаар 2022_335	оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.	дэд станц барьж байгуулах ажлын хүрээнд импортоор оруулж ирж байгаа тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварыг 2 жилийн дотор хэсэгчлэн төлөх 25/Г-27/2023/02-23/А/2023-13 дугаартай гэрээг 2023.04.07-ны өдөр Сангийн сайд, Эрчим хүчний сайд, Шивээхүрэн терминал ХХК-н гүйцэтгэх захирал, Нарийн сухайт ХХК-н гүйцэтгэх захирал нар байгуулсан.	
		2.Энэ тогтоолын 1-д заасан төслийг хэрэгжүүлж байгаа “Шивээхүрэн терминал” ХХК-тай гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай.	2.Гэрээний 1 дүгээр хавсралтад заасан 30,761,179.11 юанын үнийн дүн бүхий барааны гаалийн бүрдүүлэлтийг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 24-ний хооронд хийж, татварыг 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн дотор төлөхөөр гэрээнд тусгагдсан. Дээрх гэрээний дагуу Нарийн сухайт ХХК-ийн хилээр оруулж ирсэн бараанд хяналт тавьж ажиллаж байна. Гэрээний хавсралтад заагдсан барааг гаалийн хилээр зохих хууль, журмын дагуу нэвтрүүлэн, хяналт тавьж гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Шивээхүрэн дэх гаалийн газарт 02/1342 тоот албан бичгээр чиглэл өгсөн. 2024 оны 05 сарын байдлаар нийт 2.7 сая ам.долларын үнийн дүн бүхий тоног төхөөрөмжийг импортолж 1.5 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулалт хийсэн байна.	
Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зорилт, хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлах зарчим, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг үүрэг, Байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, Төрийн нууцад хамааруулах мэдээлэл, Албаны нууцад хамаарах мэдээлэл, Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, түүний шалгуур, Мэдээллийг нууцлах хугацаа, Төрийн болон албаны нууц тээгчид тавигдах тэмдэглэгээ, Төрийн болон албаны нууцыг ил болгох үндэслэл, журам, Төрийн болон албаны нууцтай танилцах нөхцөл, Төрийн нууцтай танилцах эрх олгох, Албан тушаалтан, иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзах үндэслэл, Төрийн болон албаны нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Аюулгүй байдлын шалгалт явуулах, Албан тушаалтан, иргэний үүрэг, Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажилтны үүрэг, Нууц хамгаалах ажилтны хууль зүй, эдийн засгийн баталгаа, Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт, Төрийн болон албаны нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, тээвэрлэх, илгээх, устгах, Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэрэг сэдвийн хүрээнд танилцуулга хийсэн.

Мөн “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны №246 тогтоолоор батлагдсан Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, Төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт шалгалт хийх журам, Төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах журам, Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам, Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах журмыг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгсөн.

Мөн Гаалийн ерөнхий газраас баталсан Гаалийн байгууллагын нууцыг хадгалах журам, Гаалийн ерөнхий газрын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын талаар товч мэдээлэл өгсөн.

ХҮРСЭН ТҮВШИН

ГЕГ-ын бүтцийн нэгж, харьяа гаалийн 18 газар, хорооны дарга нар Төрийн болон албаны нууцын хууль тогтоомжийн талаарх сүүлийн үеийн мэдээлэл авч, нууцтай харилцах, тэдгээрийг хамгаалах асуудлаар тодорхой мэдлэг чадвартай болсон.

Мөн түүнчлэн дээрх албан тушаалтнуудас гаргасан төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах асуудлаар гаргасан санал, хүсэлтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

---oOo---

1.Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.

СУУРЬ ТҮВШИН

Засгийн газрын 2020 оны №206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2-т заасан бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд нийт 26 ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тухайлбал, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52-р тогтоол, Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоол, Монгол Улс 2022 онд эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлого, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 29 дугаар тушаал, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд холбогдох журам, зааврын төсөл боловсруулах, хянах болон ГЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгүүдэд орж ажилласан

ХЭРЭГЖИЛТ

Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 29 дугаар тушаалаар Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтад өөрчлөлт орж Хуулийн хэлтсийн чиг үүрэгт “УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх” арга хэмжээ 2023 оны 03 дугаар сараас нэмэгдсэн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон тус журмын нэгдүгээр хавсралт “Хөгжлийн

бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа"-г тус тус үндэслэн тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан байна. Тус ажлын хүрээнд ГЕГ-т хамаарах тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

ХҮРСЭН ТҮВШИН

Тайлант хугацаанд УИХ-ын тогтоол - 4, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж - 1, Засгийн газрын тогтоол - 18, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл - 10, Засгийн газрын албан даалгавар - 2, нийт 33 тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж ажилласан.

---оОо---

Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар хугацаанд нь тайлагнасан байна.

СУУРЬ ТҮВШИН

Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль зэрэг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 887 хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах захиргаа болон иргэний 7 хэрэгт гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн 92 гэрээний төсөл, 13 журам, дүрмийн төсөл болон тайлант хугацаанд хуулийн хэлтэст ирсэн 373 бичиг, явсан 313 бичиг, 21 өргөдөл гомдол зэрэг нийт 707 албан бичгийн төслийг хянаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.

ХЭРЭГЖИЛТ

1.Харьяа гаалийн газар, хороодын дарга нарт “Гаалийн байгууллагаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Гаалийн байгууллагын удирдах ажилтны 2024 оны сургалт, зөвлөгөөн”-ний үеэр “1111” төвд “харьяа гаалийн газар, хороодын гаалийн улсын ахлах байцаагч нар гэж гаалийн газрын даргаасаа илүү эрх мэдэлтэй хүмүүс байна. Тус гаалийн ахлах байцаагч нарын доор гаалийн хяналт шалгалтын улсын байцаагч нар ажилладаг. Гэтэл тухайн хүмүүст долигонож байж ажил үүргээ гүйцэтгэх, бусдыг нь хясан боогдуулах, дарамт учруулах зэрэг асуудал үүсдэг. Замын-Үүд, Сэлэнгэ, Гашуунсухайт гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч нар нь ажил үүргээ сайн мэдэхгүй, сонгон шалгаруулалтаар албан тушаалд томилогдоогүй, төрийн ажлыг хуулийн хүрээнд хийж байгаа байцаагч нарт дарамт үзүүлдэг асуудлыг уг зөвлөгөөнд уламжилж өгөх”-ийг хүссэн гомдол ирсэн байна.

Иймд харьяа гаалийн газар, хороодын дарга нар гаалийн улсын ахлах байцаагч нарын ажилдаа хандах хандлага, мэргэжил, ёс зүй, ур чадварыг үнэлж, удирдлагын зүгээс шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор ирүүлэх” чиглэлийг 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02/316 дугаар албан бичгээр хүргүүлж хувийг 1111 төвд хүргүүлсэн.

2.Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/41 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлан үзээд Гаалийн ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01-1/394 дүгээр албан Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, мөн оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01-1/393 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт “Юнайтед белаз машинери инвестмент” ХХК /6024181/-ийн холбогдох мэдээллүүдийг хүссэн. Албан бичгийн хариу одоогийн байдлаар ирээгүй байна.

3.Тус хэлтсийн 2024.02.14 64 дугаартай дотоод зурвасаар Гаалийн төв лаборатори, Эрсдэлийн удирдлагын хэлтэст “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн ТБ-131-12/471 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Хамтран ажиллах гэрээ”-ний төсөлд санал авсан.

4.Тус хэлтсийн 2024.02.14-ний өдрийн 65 дугаартай дотоод зурвасаар Тариф, татварын газарт “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын төсөлд санал авсан. Танай газрын мөн оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 2024/10 дугаартай дотоод зурвасаар “саналгүй” гэсэн хариуг өгсөн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд журмын төсөлд өгөх хариу албан бичгийг хянуулах явцад Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг дахин судлан үзэх шаардлагатай гэсэн тул журмын төслийг дахин судлан үзэж саналаа ирүүлэхийг хүссэн.

5.Тус хэлтсийн 2024.02.15-ны өдрийн 66 дугаартай Барааны аниглал, үнэлгээний хэлтэст Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/151 дүгээр албан бичгээр Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай /шинэчлэн найруулга/-ийн хуульд заасны дагуу шинэчлэн боловсруулсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын төсөлд санал авсан. Уг саналд өгөх хариу албан бичгийг хянуулах явцад дахин санал авах шаардлага үүссэн тул уг журмын төсөлтэй танилцаж нэн даруй саналаа ирүүлэхийг хүссэн.

6.Тус хэлтсийн 2024.02.16-ны өдрийн 68 дугаартай дотоод зурвасаар Статистик, дүн шинжилгээний хэлтэст Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 04/541 дүгээр албан бичгээр “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-д Гаалийн ерөнхий газрын мэдээллийн системээс өгөгдөл, мэдээлэл дамжуулах, солилцох үйл ажиллагааг автоматжуулах “Хамтран ажиллах гэрээ” дээр ажилласан. Уг гэрээ одоо байгуулагдаж байна.

7.Хяналт, бүрдүүлэлтийн газарт тус хэлтсийн 2024.02.19-ний өдрийн 74 дугаартай дотоод зурвасаар “Алтан булаг чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын хөгжлийн бүс зөвлөл” ГҮТББ-ийн захирал Б.Орхоноос 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “Асуудал шийдвэрлүүлэх тухай” 24/10 дугаартай албан бичгээр захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, Эдийн засгийн хөгжлийн сайдаас хүргүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэн, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор шуурхай хангаж өгөхийг хүссэн хүсэлт ирүүлсэн байна.

Энэхүү албан бичгийг Гаалийн ерөнхий газрын даргын зүгээс Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайван, Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваасүрэн нарт “Асуудлыг танилцуулах, хариу өгөх”-өөр 2022 оны 02 дугаар сарын 19-ний өдөр цохолт хийж Хуулийн хэлтэст хуваарилагдсан байна.

Иймд Танай газрын зүгээс уг хүсэлтэд ямар байр суурьтай байгаа, Хуулийн хэлтэстэй хамтран ажиллах гаалийн улсын байцаагчийг нэн даруй томилон ирүүлэхийг хүссэн.

8.Хүний нөөцийн хэлтэст тус хэлтсийн 2024.02.19-ний өдрийн 73 дугаартай дотоод зурвасаар Төрийн албаны тухай хуульд төрийн албан тушаалын ангилал, төрлийг 10 дугаар зүйлийн 10.1.1-д “төрийн улс төрийн албан тушаал”, 10.1.2-т “төрийн захиргааны албан тушаал”, 10.1.3-д “төрийн тусгай албан тушаал”, 10.1.4-д “төрийн үйлчилгээний албан тушаал”, 10.3-д “Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ”, 46 дугаар зүйлийн 46.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол **төрийн жинхэнэ албан хаагч** нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй” гэж тус тус заажээ.

Өөрөөр хэлбэл Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-д заасан төрийн үйлчилгээний албан тушаалд тэтгэвэрт гарсан иргэнийг томилон ажиллуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна гэж ойлгогдохоор байна.

2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйл 145 дугаар зүйл “Ахмад настны хөдөлмөр эрхлэлт”, 145.1-д “Ахмад настан, тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж болно”, 145.2-т “Ажилтан өндөр насны тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй”, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар зөвлөмжид “...өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно...” гэж тус тус заажээ.

Үүнээс үзэхэд ажлын зайлшгүй шаардлагаар төрийн үйлчилгээний үндсэн орон тоонд тэтгэвэр тогтоолгосон иргэнийг “ажил гүйцэтгэх гэрээ”-ний үндсэн дээр төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр, үндсэн төрийн үйлчилгээний ангилалд хамааруулахгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болохоор хуульчилсан байна.

Харин нэгэнт тэтгэвэрт гарсан иргэнийг “ажил гүйцэтгэх гэрээ”-ээр цалин хөлс, урамшууллыг нь тохиролцсоны үндсэн дээр ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох эрх зүйн үндэслэлгүй гэж зөвлөсөн.

9.Гаалийн төв лабораторит тус хэлтсийн 2024.02.23-ны өдрийн 85 дугаартай дотод зурвасаар “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосны дагуу Засгийн газар батална”, 10.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина”,

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай” тогтоолын 223 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ...Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), ...даалгаж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр заажээ.

Өөрөөр хэлбэл Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Засгийн газрын тогтоолд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн “дотоодын зах зээлд” худалдаалсан төмрийн хүдрийг хэрхэн экспортлох талаар эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй байна.

“Монголпросцветмет” ТӨҮГ-ын Гаалийн ерөнхий газарт хандсан 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/352 дугаар албан бичиг, “Монголын хөрөнгийн бирж” ХХК-ийн зүгээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд хандсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/110 дугаартай албан бичигт үндэслэн хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн.

10.Гаалийн ерөнхий газрын зүгээс “Оюу толгой” ХХК-тай гэрээ байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд Гашуунсухайт дахь гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Ганбаярт “Гаалийн ерөнхий газрын зүгээс “Оюу толгой” ХХК-тай гаалийн салбар лаборатори байгуулах, лабораторийн магадлан шинжилгээ хийх, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, гаалийн улсын байцаагч, шинжээчийг ажилдаа ирэх болон буцах тээврийн асуудал, ажлын байрны нөхцөл зэрэг шаардлагатай бүхий л асуудлыг тусгасан “Хамтран ажиллах” цогц гэрээ байгуулахаар уулзалт зохион байгуулсан.

Иймд тус “Хамтран ажиллах” цогц гэрээг байгуулахад танай газрын зүгээс тусгах шаардлагатай бүхий л асуудлыг нэгтгэн 2024 оны 03 дугаар сарын 02-ны дотор ирүүлэхийг мэдэгдье. Жич: “Хамтран ажиллах” цогц гэрээ нь урт хугацаатай байгуулагдах бөгөөд орхигдуулсан саналыг дахин гэрээнд тусгах боломжгүй” гэж 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 02-1/791 дугаартай албан бичгээр хүргүүлэн саналыг авч ажилласан. Одоо ГЕГ болон Оюу толгой ХХК-ийн хооронд гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг хүрээнд хянаж байна.

11.Санхүү, хөрөнгө газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 30 дугаартай дотоод зурвасыг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авч танилцаад “Гаалийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмжүүдийг Орхон аймаг дахь гаалийн газрын балансаас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын балансад шилжүүлж болох эсэхэд манай хэлтсийн зүгээс тусгайлан эрх зүйн зөвлөмж өгөх боломжгүй байна. Иймд энэ талаарх асуудлыг Сангийн яаманд уламжлаж шийдвэрлүүлэхийг хүсье” гэж холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг хүрээнд зөвлөмж өгч ажилласан.

12.Гаалийн ерөнхий газар болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хооронд байгуулагдах “гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах” гэрээний төсөлтэй танилцаад “Уг гэрээний төсөлд “Дэд дарга Г.Энхтайван” гэснийг “Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайван”, “Тав. Хариуцлага” гэснийг “Зургаа. Хариуцлага” гэж өөрчлөх” саналтай байна.

Цаашид “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т гэрээний төслийг танилцуулж гэрээ байгуулах ажиллагааны явцад манай хэлтсээс эрх зүйн зөвлөгөө авах, хуульд нийцсэн эсэхийг хянуулах боломжтой” гэсэн эрх зүйн зөвлөмжийг тус хэлтсийн 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 113 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.

13.Эрсдэлийн удирдлагын хэлтсийн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2024/85 дугаартай дотоод зурвастай танилцаад “Гаалийн ерөнхий газар Зорчигчийн мэдээллийн төвийн хооронд байгуулагдах “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ”-ний төсөлд тус хэлтсийн зүгээс тусгайлан өгөх саналгүй болно” гэдгийг тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 179 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.

14.Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газарт тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01-1.2/2025 дугаартай албан бичгээр “Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Б/227 дугаар тушаалаар гаалийн улсын ахлах байцаагч П.Даариймаад гаалийн хяналт шалгалт хийсэн гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд гаалийн улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс бусдад тарифын бус хязгаарлалттай барааг хилээр нэвтрүүлэх боломж олгож Засгийн газрын 2009 оны 90 дүгээр тогтоол, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 36/32 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байх тул сануулах сахилгын шийтгэл ногдуулж, сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаа дуусах хүртэл үр дүнгийн шагнал, урамшуулал олгохгүй байхыг Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт тус тус даалгаж шийдвэрлэжээ.

Үүнээс үзэхэд сахилгын шийтгэлтэйд тооцохоос өмнөх ажилласан хугацааны үр дүнгийн шагнал, урамшуулал олгосон нь зөв.

Харин Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 90 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Гаалийн улын байцаагчийн сахилгын дүрэм”-ийн 6.7-д “Гаалийн улсын байцаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 36/32 дугаар тушаалын 9.3-т “Албан хаагчид сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаанд шагнал, урамшуулал олгохгүй байхаар холбогдох журамд зааж болно” гэж тус тус заажээ.

Иймд гаалийн улсын ахлах байцаагч П.Даариймаад Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Б/227 дугаар тушаалаар сахилгын шийтгэлтэйд тооцсон байх тул уг өдрөөс эхлэн 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй тохиолдолд сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаа дуусах хүртэл үр дүнгийн шагнал, урамшуулал олгохгүй болохыг үүгээр зөвлөж байна.

Гаалийн улсын ахлах байцаагч П.Даариймаад 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр сахилгын шийтгэл ногдуулсан байх тул тухайн сарын ажлын үр дүнгийн үзүүлэлтийг уг тушаалтай холбогдуулан тооцох нь зөв” гэсэн зөвлөмж, чиглэлийг өгсөн.

15.Тус хэлтсийн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 233 дугаартай дотоод зурвасаар Аж ахуй, үйлчилгээний албанд

1. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хуульд “Байнгын гэрээт ажилтан” гэсэн нэр томъёо байхгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалын хавсралтын “Үндсэн цалин”-д “Байнгын гэрээт ажилтан” гэж байгаа ч холбогдох хуульд ийм нэр томьёо байхгүй байгаа тул “Байнгын гэрээт ажилтан гэж ямар ажилтан байх” гэсэн асуултад тусгайлан эрх зүйн зөвлөмж өгөх боломжгүй байна. /Хүчингүй болсон Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-т “байнгын ажлын байр” гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүргийг” гэж заасан байсан байна/

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “ажлын байр” гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байрыг”, Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4-д “Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, **хөдөлмөрийн гэрээ**, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох **талууд дагаж мөрдөх үүрэгтэй**”, 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “**хөдөлмөрийн гэрээ**” гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоны дагуу хийсэн тохиролцоог”, 6 дугаар зүйлийн 6.8-д “Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, **хөдөлмөрийн гэрээ**, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний зохицуулалт нь **хүнийг ялгаварлан гадуурхсан, эрхийг нь хязгаарласан, эсхүл давуу байдал олгосон бол тухайн зохицуулалт хүчин төгөлдөр бус байна**” гэж тус тус заажээ.

Үүнээс үзэхэд ажил олгогч, ажилтан хоёр ажлын нөхцөл, нэр томьёо хэрхэн байгаагаас үл хамаарч хөдөлмөрийн гэрээ заавал байгуулахаар байна.

3. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4-т “батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох”, 9 дүгээр зүйлийн 9.1-д “Агентлагийн орон тооны дээд хязгаарыг Засгийн газар, агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газраас тогтоосон ерөнхий загварыг баримтлан Монгол Улсын сайд батална”, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/142 дугаар тушаалын 4.3.12-т “гаалийн удирдах төв байгууллагаас баталсан бүтэц, орон тооноос хэтрүүлэхгүй... төрийн үйлчилгээний албан хаагчдыг ажилд авах, ажлаас халах...” гэж тус тус заасан байна.

Иймд Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороод батлагдсан бүтэц, орон тоонд ажилтан авч ажиллуулахаар байна.

Дашрамд сонирхуулахад Үндэсний статистикийн хорооны сайтад Цалин хөлстэй ажиллагчид гэж хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэнийг ойлгоно.

Байнгын ажилтан гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Төрийн албаны тухай хууль, тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг ойлгоно.

1. Албан ажлаа түр эрхлээгүй байгаа байнгын ажилтанд ээлжийн амралтаа авсан, ажил хаясан, үйлдвэрлэлийн сул зогсолт гарч байгууллагын эдийн засгийн

үйл ажиллагаа түр хугацаагаар тасалдсан болон зургаан сар хүртэлх хугацаагаар өвчтэй байсан, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, суралцах, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй зэрэг шалтгаанаар ажлаа хийгээгүй боловч хөдөлмөрийн гэрээ цуцлаагүй бөгөөд ажлын байр нь хадгалагдаж байгаа эргэн ажиллах, байнгын ажлын байранд албан ёсны гэрээтэй иргэнийг хамруулна.

2. Улирлын ажилтанд улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль, тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хамруулна.

Гэрээт ажиллагчид ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс, урамшуулал авдаг байнгын ажилтанд хамаарахгүй иргэнийг хамруулна” гэсэн зөвлөмжийг өгсөн.

16. Хүний нөөцийн хэлтсийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 156 дугаартай дотоод зурвас, түүнд хавсаргасан Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын Хяналт, шалгалтын албаны Хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч Ц.Батсүхийн Гаалийн ерөнхий газрын даргад гаргасан хүсэлттэй танилцаад Гаалийн улсын ахлах байцаагч Ц.Батсүхийн хүсэлтийн агуулгаас үзэхэд хоёр төрлийн агуулгатай хүсэлт гаргасан байх бөгөөд дараах байдлаар эрх зүйн зөвлөмж өгч байна. Үүнд:

1. 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл “Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 280.7 дахь хэсэг нэмсүгэй”, “280.7. Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа **гаалийн улсын байцаагчид** таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгоно”, Гаалийн тухай хуулийн 273 дугаар зүйлийн 273.1-д “Гаалийн хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт хийх эрх эдэлж, үүрэг хүлээх гаалийн албан тушаалтныг гаалийн улсын байцаагч гэнэ” гэж тус тус заажээ.

Гэтэл гаалийн улсын ахлах байцаагч Ц.Батсүхийн гаргасан хүсэлт, түүнд хавсаргасан баримтаас үзэхэд Засгийн газрын Өмнөговь аймаг дахь Бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын албаны хилийн боомт харицсан мэргэжилтэн, Боомтын нэгдсэн захиргааны Хөгжлийн газрын даргаар ажиллаж байсан хугацааг гаалийн байгууллагад ажилласан хугацаанд тооцохооргүй байна.

Учир нь түүний ажиллаж байсан Боомтын нэгдсэн захиргаа нь өнөөдрийг хүртэл хууль тогтоомжоор гаалийн байгууллагын бүтцэд нэгдээгүй.

2. Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 46.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах **насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч** төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр **төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана.** Төрийн жинхэнэ албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй

нь захиргааны санаачилгаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй” гэж заажээ.

Иймд гаалийн улсын ахлах байцаагч Ц.Батсүхийн үйл ажиллагааны **үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг** харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулах эсэхийг гаалийн байгууллагын удирдлагатай тохиролцсны үндсэн дээр шийдвэрлэх нь зөв гэсэн зөвлөмжийг тус хэлтсийн 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 243 дугаартай дотоод зурвасаар хүргүүлэн холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-962.5 сая төгрөг.

Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/131 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.04.15-ны өдөр нээлттэй зарлан 2024.05.07-ны өдөр нээхэд Масс теч ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан.

- Цацрагийн хяналтын төхөөрөмж шилжүүлэн суулгах засвар /Алтанбулаг, Боршоо/-306.0 сая төгрөг

Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/202 тушаалаар тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендер амжилтгүй болсон тул Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024.05.06-ны өдөр дахин нээлттэй зарлаж, 2024.05.27-ны өдөр нээхэд Масс Теч ХХК тендер ирүүлснийг шаардлага хангасан тендер гэж үнэлэн гэрээ байгуулсан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/186 тушаалаар “Гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмжүүдийн засвар” тендер шалгаруулалтын Үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/250 тушаалаар “Гаалийн мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах техник хэрэгсэл” тендерт үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/242 тушаалаар “Гаалийн байгууллагын албан хаагчдын дүрэмт хувцас нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерт үнэлгээний хорооны гишүүнээр орж ажиллаж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг үндэслэн мөн хуулийн 21 дүгээр зүйлд заасан хариуцагчийн эрх, үүрэг болон 28 дугаар зүйлийн 28.2.1-т “нэхэмжлэлд гарын үсэг зурах, хариу тайлбар гаргах”, 28.2.6-т “шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах” гэж заасан эрхийг хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны эхний хагас жилд нийт 2 захиргааны хэрэгт Гаалийн байгууллагыг төлөөлөн ажилласан.

ЭХХШТХ-ийн 9.5-ын 4-т заасан хохирогчийн эрх, үүрэг хэрэгжүүлэх хууль ёсны төлөөлөгчөөр мөн хуулийн 8.1-ийн 4-т заасныг үндэслэн 2024 оны эхний хагас жилд нийт 4 тогтоосон байх тул ГЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримт, мэдүүлэг өгөх зэргээр ажилласан.

ХҮРСЭН ТҮВШИН

Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар ХШҮДАГ-аас тогтоосон хугацаанд тайлагнасан.

---oOo---

7.1.Нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн байна.

СУУРЬ ТҮВШИН

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний түвшинд нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байгаагүй болно.

ХЭРЭГЖИЛТ

1.ГЕГ-ын даргын “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2024 оны №А/123 тушаалын 1 дүгээр хавсралтын 9-д Хуулийн хэлтэс нь дарга 1, гаалийн улсын ахлах байцаагч 1, гаалийн улсын байцаагч 5 байхаар тогтоосон.

2022 онд тус хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч Хуулийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсоноос хойш тухайн албан тушаалын сул орон тоо үүссэн.

Орон тооны нөхөн хангалт хийгээгүйгээс ТАЗ-ийн 2023 оны №62 тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Албан тушаалын тодорхойлолтод заасан гаалийн улсын ахлах байцаагчийн албан тушаалын зорилго, чиг үүрэгт заагдсан удирдан зохион байгуулах, тайлан төлөвлөгөө боловсруулах зэрэг бодлогын шинжтэй болон бусад ажил, үүрэг хийдэх, Хуулийн хэлтсийн ажил үүрэг орхигдох эрсдэл үүсч байна.

2.Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад тус хэлтсийн АЗ сертификаттай 2 байцаагч байнга үнэлгээний хороонд оролцож байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх, авлигатай тэмцэх байгууллагад ташаа ойлголт төрүүлж болзошгүй эрсдэлтэй байна.

Үүний зэрэгцээ үнэлгээний хороонд бараа, ажил, үйлчилгээг ашиглах, тусгай мэдлэгтэй, чиг үүргийн байцаагчийг албан ёсоор оруулах шаардлагатай ба энэ нь худалдан авах ажиллагаа бодитой бус худалдан авалт явагдах эрсдэлээс сэргийлнэ.

3.Сангийн сайдын “ГЕГ-ын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 2024 оны №06 тушаалын хавсралтын 3.3.1.2-т Хуулийн хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхой заасан.

Харин тус хэлтэс дээрх үндсэн үүрэг, үүрэгт хамааралгүй чиг үүрэг гүйцэтгүүлэх, бусад нэгжийн эрхлэх асуудлын хүрээний албан бичиг, өргөдөл гомдол, үүрэг, даалгавар гүйцэтгүүлж байгаа нь албан хаагчдад мэргэжлийн бус алдаа гаргах, гаалийн байгууллагын талаар буруу, ташаа ойлголт төрүүлэх эрсдэлтэй байна.

4.Илүү цагаар ажилласан хугацааг 17.30 цагаас хойш тооцож олгож байгаатай нэгэн адил 08.30-аас өмнө илүү цагаар ажилласан хугацааг тооцож нэмэгдэл хөлсийг олгодог болох нь албан хаагчдын хугацаатай үүрэг даалгавар биелүүлэхээс халшрах эрсдэлээс сэргийлнэ.

5.Монгол хэлний тухай хуульд, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахаар, мөн **“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн 2.1-д 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулахаар тус тус заасан.**

Харин тус хэлтсийн албан хаагчдийн монгол бичгийн мэдлэгийн түвшин тодорхойгүй, гаалийн байгууллагаас монгол бичгийн сургалт хүртээмжтэй зохион байгуулаагүй нь 2025 оноос эхлэн хэрэгжих дээрх хууль, тогтоолыг хэрэгжилт тасрах, албан хэрэг хөтлөлтийн явцад алдаа гарах эрсдэлтэй байна.

6.ГЕГ-ын хүний нөөцийн асуудлаар баталсан тушаалаас үүссэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд түүнийг боловсруулсан хүний нөөцийн нэгжийн албан хаагчийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцуулах нь энэ төрлийн хэрэг маргаан нэмэгдэх, гаалийн байгууллагаас цалин нөхөх олговрыг хэлбэрээр төлдөг өр төлбөр ихсэх цаашид дээрх асуудлаар гарах хэрэг маргаан үүсэх эрсдэлээс сэргийлнэ.

7.Сангийн сайдын “ГЕГ-ын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 2024 оны №06 тушаалын хавсралтын 3.3.1.2-т Хуулийн хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүрэгт төрийн болон байгууллагын нууцын асуудлыг хариуцахаар заасан.

Энэ чиг үүргийг нууц хамгаалах ажилтан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хягаарлагдмал хүрээнд туслах эрх бүхий албан хаагчийг томилон ажиллуулах нь төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлээс сэргийлнэ.

8.Хуулийн хэлтсийн албан хаагчдыг захиргаа, иргэн, эрүүгийн чиглэлээр гэрээний эрх зүйн орчин үеийн асуудлаар холбогдох сургалтад тогтмол хамруулах нь хянаж байгаа гэрээ хууль тогтоомж зөрчих, иргэн, байгууллагад хохирол учрах эрсдэлээс сэргийлнэ.

ХҮРСЭН ТҮВШИН

Хуулийн хэлтсээс таньж тогтоосон, үндсэн үүрэг, чиг үүргийг хэрэгжүүлэх явцад үүсч болзошгүй гэж үзсэн нэгжийн 8 дотоод эрсдэлийг тодорхойлж 2024 оны эхний хагас жилийн байдлаар ангилж санд бүртгэсэн.

---oOo---

7.2.Нэгжийн дотоод эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулсан байна.

СУУРЬ ТҮВШИН

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний түвшинд нэгжийн дотоод эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулагдаж байгаагүй..

ХЭРЭГЖИЛТ

Нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж үүсч болзошгүй гэж үзсэн 8 /9/ эрсдэлийг санд бүртгэсэн.

Энэхүү таньж тогтоосон эрсдэлийг бууруулах талаар дараах “Нэгжийн дотоод эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г боловсруулсан. Тухайлбал,

**БАТЛАВ.
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ**

Ч.ТАМИРАА

**НЭГЖИЙН ДОТООД ЭРСДЭЛИЙГ
БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

/2024.06.25-12.31/

№	Эрсдэл	Арга хэмжээ	Хугацаа	Албан хаагч
1.	Гаалийн улсын ахлах байцаагчийн албан тушаалын зорилго, чиг үүрэгт заагдсан удирдан зохион байгуулах, тайлан, төлөвлөгөө боловсруулах зэрэг бодлогын шинжтэй болон бусад ажил, үүрэг хийдэх, Хуулийн хэлтсийн чиг үүрэг орхигдох эрсдэл	ХНХ-т нөхөн хангалт хийлгүүлэх шийдвэр гаргуулах талаар санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа
2.	А3 сертификаттай 2 байцаагч байнга үнэлгээний хороонд оролцож байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх, АТГ-т ташаа ойлголт төрүүлэх эрсдэл	СХОГ-т албан хаагчдыг А3 сертификат эзэмшүүлэх талаар санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа
3.	Бараа, ажил, үйлчилгээг ашиглах, тусгай мэдлэгтэй, чиг үүргийн байцаагчийг үнэлгээний хороонд албан ёсоор оруулах шаардлагатай ба энэ нь худалдан авах ажиллагаа бодитой бус худалдан авалт явагдах эрсдэл	СХОГ-т албан хаагчийн оролцуулах санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа
4.	Үндсэн үүрэг, үүрэгт хамааралгүй чиг үүрэг гүйцэтгүүлэх, бусад нэгжийн эрхлэх асуудлын хүрээний албан бичиг, өргөдөл гомдол, үүрэг, даалгавар гүйцэтгүүлэх нь албан хаагч мэргэжлийн бус алдаа гаргах, гаалийн байгууллагын талаар буруу, ташаа ойлголт төрүүлэх эрсдэл	Дэд дарга, ЗУГ, ХНХ-т санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа
5.	Илүү цагаар ажилласан хугацааг 17.30 цагаас хойш тооцож олгож байгаатай нэгэн адил 08.30-аас өмнө илүү цагаар ажилласан хугацааг тооцож нэмэгдэл хөлсийг олгодог болох нь албан хаагчдын хугацаатай үүрэг даалгавар биелүүлэхээс халшрах эрсдэлээс сэргийлнэ	ЗУГ, ХНХ-т санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа
6.	Албан хаагчдийн монгол бичгийн мэдлэг, чадварын түвшин тодорхой бус, гаалийн байгууллагаас монгол бичгийн сургалт хүртээмжтэй зохион байгуулаагүй нь албан хэргийг 2025 оноос эхлэн хос бичгээр	ЗУГ, СТ-д санал хүргүүлэх	III, VI улиралд	Ний албан хаагчид

	хөтлөхөөр заасан хууль тогтоомжийн хэрэгжилт тасрах, албан хэрэг хөтлөлтийн явцад алдаа гарах			
7.	Хүний нөөцийн асуудлаар баталсан тушаалаас үүссэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд түүнийг боловсруулсан хүний нөөцийн нэгжийн албан хаагчийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцуулах нь энэ төрлийн хэрэг маргаан нэмэгдэх, гаалийн байгууллагаас цалин нөхөх олговрыг хэлбэрээр төлдөг өр төлбөр ихсэх цаашид дээрх асуудлаар гарах хэрэг маргаан үүсэх эрсдэлэлээс сэргийлнэ	ХНХ-т санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа
8.	Нууц хамгаалах ажилтан хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хягаарлагдмал хүрээнд туслах эрх бүхий албан хаагчийг томилон ажиллуулах нь төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчигдөх эрсдэл үүсэхээс хамгаална	ДХАБХ-т санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа
9.	Захиргаа, иргэн, эрүүгийн чиглэлээр гэрээний эрх зүйн орчин үеийн асуудлаар холбогдох сургалтад тогтмол хамруулах нь хянаж байгаа гэрээ хууль тогтоомж зөрчих, иргэн, байгууллагад хохирол учрах эрсдэлээс сэргийлнэ	ЗУГ, СТ-д санал хүргүүлэх	III, VI улиралд	Ч.Тамираа

ХҮРСЭН ТҮВШИН

2024 оны III, IV улиралд хэрэгжүүлэх “Нэгжийн дотоод эрсдэлийг бууруулах төлөвлөгөө” Эрсдэл, Хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах, оролцох албан хаагч гэсэн агуулгын хүрээнд 9 зүйлийн эрсдэлийг бууруулна гэж тооцон төлөвлөгөө боловсруулав.

---oOo---

1.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүний мэдээллийг тухай бүр түгээсэн байна.

СУУРЬ ТҮВШИН

1.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүний мэдээллийг тухай бүр түгээж ажилласан.

ХЭРЭГЖИЛТ

Тайлант хугацаанд дараах хууль, Засгийн газрын тогтоолыг цахим хуудсанд байршуулж мэдээллэв. Үүнд:

1. **Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.** /2024 оны 01 сарын 12 өдөр/
2. **Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай.** 2024 оны 04 сарын 19 өдөр /2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг

тасалдуулахгүй байх зорилгоор импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг/

3. **“Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоол**
/Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилын жагсаалт/
4. **Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль.** 2024 оны 05 сарын 16 өдөр. 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа Булевиртид эмийг.
5. **Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай.** 2024 оны 05 сарын 16 өдөр
2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа Булевиртид эмийг.
6. **“Экспортлох хэмжээг тодорхой хугацаагаар хориглох тухай” Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн №225 тогтоол**
/Идлэг шонхор шувууг ашиг олох зорилгоор гадаад улсад гаргахыг 5 жилийн хугацаатай/

ХҮРСЭН ТҮВШИН

Гадаад худалдаа, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын асуудлаар баталсан 4 Монгол уулсын хууль, 2 Засгийн газрын тогтоолыг цахимаар түүгээж сурталчилсан.

1.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүний мэдээллийг тухай бүр түгээсэн байна.

СУУРЬ ТҮВШИН

Тайлангийн хугацаанд өгсөн ГЕГ-н дарга болон холбогдох дээд шатны байгууллагын өгсөн 34 үүрэг даалгаврыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэж, гаалийн тухай хуульд заасан үндэслэлээр гаалийн байгууллагад үүсээд буй өр авлагыг барагдуулах талаар удаа дараа шаардсаны үр дүн “Улаанбаатар хөгжлийн корпораци” ХК-ийн импортолсон БНХАУ-д үйлдвэрлэсэн цэнэглэгч цахилгаан мотор 2 ширхэг, 10 ширхэг цахилгаан автобусны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар нийт 22,900,408,648.16 /хорин хоёр тэрбум есөн зуун сая дөрвөн зуун найман мянга зургаан зуун дөчин найман төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгийг өрийг бүрэн төлж барагдуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Тайлант хугацаанд serp.ecustoms.mn-ээр өгсөн нийт 14 үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлж дүгнүүлсэн.

Мөн Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороодын дарга нар хууль тогтоомжийн дагуу эрх хэмжээний хүрээнд 1 дүгээр улиралд батлан гаргасан захиргааны акт /тушаал, гэрээ/-д хувийн хэргийн хөтлөлтийг хийж гүйцэтгэхийг харьяа гаалийн газар, хороодод онлайн хурлаар өгч биелэлтийг хугацаанд нь авч ХШҮДАГ-аар дүгнүүлж, ЧХОУНБГГ-т тус газрын даргын тушаал шийдвэрт зөвлөмж өгч ажилласан.

Тайлант хугацаанд удирдлагаас болон бусад нэгжүүдээс serp.ecustoms.mn-ээр өгсөн нийт 14 үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хуулийн дагуу биелүүлж тайлагнасан. Үүнээс 13 үүрэг даалгавар нийт 92.69 хувиар дүгнэгдсэн. Харин 1 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд тайлагнасан, холбогдох нэгжээс дүгнээгүй байна.

ХЭРЭГЖИЛТ

1. Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, Барааны ангилал, үнэ үнэлгээний хэлтсээс Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/4581 дугаартай албан бичгээр “Санчир-Ундрах” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын нэр бүхий гаалийн улсын байцаагч нарт холбогдох захиргааны хэрэгт нотлох баримт шаардсан байна. Иймд уг албан бичгийн 2, 3 дахь хэсэгт заасан нотлох баримт болон бусад шаардлагатай гэсэн баримтуудыг тус хэлтэст ирүүлэхийг мөн оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 241, 242 дугаартай дотоод зурвасаар авч шүүхэд хүргүүлсэн.

2. Захиргааны удирдлагын газар, Хяналт бүрдүүлэлтийн газар, Зөрчилтэй тэмцэх газар, Хорио цээрийн хэлтэс, Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Боомтын хэлтсээс Хилийн боомтын захиргааны 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 24/153 дугаартай албан бичгээр “Мэдээлэл солилцож хамтран ажиллах тухай гэрээ”-ний төсөлд санал авч нэгтгэн Дэд даргад танилцуулж хүргүүлэхэд бэлэн болоод байна.

3. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу тус шүүхэд “Морь эскпресо” ХХК-ийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээг Статистик, дүн шинжилгээний хэлтсээс гаргуулан нийт 7 хуудас баримтыг мөн оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 01-1.2/2109 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

4. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 79 дугаартай дотоод зурвасыг мөн оны 05 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч танилцаад “Гаалийн ерөнхий газар болон “Нанопланет” ХХК-ийн хороонд байгуулагдах “Хүний биеийн халуун хэмжигч, металл мэдрэх зориулалттай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж /Улсын хэмээнд/ нийлүүлэх гэрээ”-ний төсөлд хууль эрх зүйн хувьд тусгайлан өгөх саналгүй болно гэж тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 29-ны өдрийн дотоод зурвасаар хүргүүлсэн.

5. Аж ахуй, үйлчилгээний албанаас ирүүлсэн “Монгол хьондай автомотив” ХХК-тай байгуулах “Авто машины засвар үйлчилгээ хийх гэрээ”, “Эл даблью органик футур ар” ХХК-тай байгуулах “Худалдах худалдан авах гэрээ”-ний төсөлтэй танилцаад

1. “Эл даблью органик футур ар” ХХК-тай байгуулах “Худалдах худалдан авах гэрээ”-ний “Гэрээ байгуулсан” хэсэгт Сургалтын төвийн эрх бүхий албан тушаалтныг тусгах.

2. Уг гэрээний төслийн 2 дугаар хавсралт нь хянагдаагүй болно.

3. “Монгол хьюндай автомотив” ХХК-тай байгуулах “Авто машины засвар үйлчилгээ хийх гэрээ”-д Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5, 342-358 дугаар зүйлийг тусгах.

4. “Гэрээ байгуулсан” хэсэгт Санхүү, хөрөнгө оруулалтын газрын эрх бүхий албан тушаалтныг тус тус нэмэх саналыг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 246 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.

6. Статистик, дүн шинжилгээний хэлтсээс Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 4-190/1781 дугаар албан бичгээр “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК-ийн 2015 оны 01 дүгээр сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд хийсэн гаалийн бүрдүүлэлтийн дэлгэрэнгүй лавлагаа, мэдээллийг хүссэн тул тус хэлтсийн 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 40 дугаартай дотоод зурвасаар хүргүүлж хариуг хүлээн авсан.

7. Бүрдүүлэлтийн цахим төвд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 4-190/1781 дугаар албан бичгээр “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК гаалийн бүрдүүлэлт хийхээр гаалийн байгууллагад хандах бүрт хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгч /89086190/-д нэн даруй мэдэгдэн хамтран ажиллахыг хүссэн.

Иймд тухайн “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК гаалийн бүрдүүлэлт хийхээр гаалийн байгууллагад хандсан тохиолдолд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэн хамтран ажиллахыг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 41 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.

8. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 4-190/1781 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Статистик, дүн шинжилгээний хэлтсээс “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны мэдээлэл гаалийн мэдүүлгийн санд бүртгэгдээгүй болохыг тодруулан цаашид “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК гаалийн бүрдүүлэлт хийхээр хүсэлт гаргасан тохиолдолд танай байгууллагад мэдэгдэн хамтран ажиллахыг болохыг 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-1/2/313 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

9. Тус хэлтсийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 52 дугаартай дотоод зурвасаар Хяналт, бүрдүүлэлтийн газар, Татвар, орлогын газарт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/151 дүгээр албан бичгээр Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай /шинэчлэн найруулга/-ийн хуульд заасны дагуу шинэчлэн боловсруулсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын төсөлд санал авч байгаа тул уг саналтай танилцаж 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 17 цаг 00 минутаас өмнө санал авсан.

